



**“ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-ИЙН
ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ
“КАТОДЫН ЗЭС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР”-ИЙН ДЭД БҮТЦИЙН БАРИЛГА
БАЙГУУЛАМЖ БАРИХ ТӨСӨЛ**

**2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар-5388082
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар-9011779093**

Биелэлтийг тайлагнасан.

“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Б.Мөнхбаатар



Боловруулсан:

“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн
Байгаль орчны ахлах мэргэжилтэн
Байгаль орчны ажилтан

Ц.Мэндбаяр

Б.Сансар

Ц.Мэндбаяр
Б.Сансар

2023 он
Орхон аймаг



АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	1-8
1.1. Төслийн зорилго.....	1
1.2. Төслийн байршил.....	2-3
1.3. Төсөл хэрэгжүүлэх үндсэн суурь нөхцөл.....	3-4
1.4. Хүдэр тээвэрлэх процесс.....	4-5
1.5. Үйлдвэрийн технологийн процесс.....	5-8
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	8-13
2.1. Байгалийн мужлал.....	8
2.2. Газар зүйн байрлал, газрын гадарга.....	8
2.3. Цаг уур, уур амьсгал.....	8-10
2.4. Гадаргын ба газрын доорх усны өнөөгийн төлөв байдал.....	10
2.5. Хөрсөн бүрхэвчийн өнөөгийн төлөв байдал.....	10-11
2.6. Ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдал.....	11
2.7. Амьтны аймгийн өнөөгийн төлөв байдал.....	11-12
2.8. Нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал.....	12
2.9. Орон нутгийн иргэдийн нийгэм-эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл.....	12-13
2.10. Түүх соёлын өвийн өнөөгийн төлөв байдал.....	13
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13-14
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	14-60
4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	15
4.1.1. Төслийн талбай орчим болон ажлын байрны доторх агаараас NO ₂ , SO ₂ , PM ₁₀ , PM _{2.5} сорьц дээж авч, шинжилгээ хийх, түвшинг тодорхойлох.....	15-17
4.1.2. Төслийн усан халаалтын зуухнуудад үнс баригч, шүүлтүүр суурилуулах, арчилгаа, засвар үйлчилгээг цаг тухай бүрд хийж байх.....	17
4.1.3. Төслийн талбайн бүтээн байгуулалтын зам, талбайд тоосжилт үүсэхээс сэргийлэх орчин үеийн эко технологийг сонгож нэвтрүүлэх.....	17-21
4.1.4. Уурын зуухны яндангаас ялгарч буй бохирдуулагч бодисын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.....	22-23
4.1.5. Төслийн талбайд ашиглаж буй автомашинуудыг оношилгоо, үзлэгт хамруулах, өдөр тутамд хотын замын хөдөлгөөнд оролцдог тээврийн хэрэгслийн янданд утаа шүүгч тоног, төхөөрөмж суурилуулах.....	23-24
4.1.6. Гадаад орчны тоосжилт дарах усалгааг хийх.....	24-25



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

4.2. Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	25
4.2.1. Бохир хуримтлуулах цооног дүүрч хальж асгарснаас хөрс, бага гүнд орших газар доорх ус бохирдож болзошгүй тул цаг тухайд нь соруулж байх, бохирын цооногийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавих.....	25-27
4.2.2. Гүний худгуудын нөөцийг хянах түвшин хэмжигч багажийг бэлтгэл цооногт тавьж, түвшнийг ажиглаж худгуудын үйл ажиллагаа усны нөөцийг хянах...	27-30
4.2.3. Гүний усны мониторингийн цооногуудаас сар бүр сорьц авч итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх.....	30-32
4.2.4. Ус ашиглалттай холбоотой хууль эрхзүйн бичиг баримтуудын бүрдүүлэлтийг хангах.....	32-35
4.2.5. Ус хэрэглээний бүртгэл хөтөлнө. Усны зарцуулалтыг тооцож байх, төслийн усны хэрэглээнд ашиглаж буй эх үүсвэр /худгууд/-ийн бичиг баримтын бүрдлийг хангаж ажиллах.....	35-38
4.3. Хөрсний чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	38
4.3.1. Авто машины орох, гарах маршрутыг нарийвчлан тогтоох, олон салаа зам гаргахгүй байх, тэмдэг тэмдэглэгээ байршуулах.....	38-40
4.3.2. Хаягдал тосыг мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх, хөрсөнд алдагдахаас урьдчилан сэргийлэх.....	40-43
4.3.3. Бороо, үерийн уснаас хамгаалах далан шуудууг тогтмол шалгаж, үерийн урсац шороогоор дүүрэхээс сэргийлэх.....	44
4.3.4. Төслийн талбайн орчмын хөрсний бохирдлыг тодорхойлох, хөрсний чанарын мониторинг үнэлгээ хийлгэх.....	45-47
4.3.5. Эвдэрсэн талбайн бүртгэл хөтөлж, ашиглалтын үед үүссэн жижиг талбай, эвдрэлийг тэгшилж хэлбэржүүлэх.....	47-49
4.3.6. Химийн бодис хөрсөнд асгарсан тохиолдолд хөрсийг солих, саармагжуулж хаях арга хэмжээг авах, саармагжуулах материалууд бэлэн байлгах, асгаралт саармагжуулах журам боловсруулж мөрдөх.....	49-51
4.4. Ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	51
4.4.1. Боломжит газруудад ногоон байгууламжийг зохих арга технологийн дагуу байгуулах.....	51-52
4.4.2. Ургамлан нөмрөгийн өсөлт, хөгжилт, өөрчлөлтөд тодорхой давтамжтайгаар мониторинг буюу судалгааг хийлгэх.....	53-55
4.4.3. Төслийн талбайд тариалалт хийх зориулалт бүхий мод үржүүлгийн газар байгуулах.....	55-58



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

4.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	58
4.5.1. Төсөл хэрэгжих сум орон нутгийн амьтны аймгийн төрөл зүйл, тархалт, тоо толгойн талаарх мониторинг судалгааг хийлгэх.....	58-59
4.5.2. Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамд шувуу үргээгч суурилуулж шувуу хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх.....	59
4.5.3. Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамын шувуу цахилгаанд цохиулж буй эсэх хяналт судалгаа хийх.....	60
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	60-69
5.1. Төслийн талбайд тохижуулалтын журмаар мод тариалах, ногоон байгууламж бий болгох, тариалалт хийх талбайн хөрсийг бордох сайжруулах, мод усалгаа, арчилгааг тогтмол гүйцэтгэх.....	60-62
6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	62
6.1. “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд хавар, намрын бүх нийтээрээ мод тарих өдрүүдээр 2022 онд тарьсан ногоон зурвасаа үргэлжлүүлж 1000 –с дээш навчит болон шилмүүст моднуудыг тарьж ургуулж хамгаалах.....	62-67
6.2. “COPPER FESTIVAL” эвент арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн, хамтран зохион байгуулах.....	67-69
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	69-70
7.1. Төслийн талбайн орчимд зуны улиралд нутаглаж буй малчин өрхүүдэд малаа хариулгатай байлгаж, төслийн талбайн нөлөөллийн бүсэд бэлчээрлүүлэхгүй байх талаар мэдэгдэл хүргэх, бүлгийн уулзалт хийх.....	69-70
8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	70-71
8.1. Үйлдвэрийн талбайд археологийн олдвор илэрсэн тохиолдолд хуулийн дагуу БОХУБ-д мэдээлж ажиллана.....	70-71
8.2. Үйлдвэрийн талбайд палеонтологийн олдвор илэрсэн тохиолдолд хуулийн дагуу БОХУБ-д мэдээлж ажиллана.....	71
9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	71-85
9.1. Химийн бодисын тусгай зөвшөөрөл, химийн бодисын орлого зарлагын бүртгэл хөглөх, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах.....	71-72
9.2. Химийн бодистой харьцах ажилтны сургалтад холбогдох ажилчдыг хамруулах.....	73-74
9.3. Химийн бодисын асгаралт үүсвэл саармагжуулалт хэрхэн хийх талаар журам боловсруулж мөрдөх, химийн бодисыг цэвэрлэх, саармагжуулах арга хэмжээ авах, багаж хэрэгсэлтэй байх.....	74-75
9.4. Ажилчдыг нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хор саармагжуулах бүтээгдэхүүнээр хангах.....	76-78



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

9.5. Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж (утаа зайлуулах систем, галын автомат систем, ус хангамж, галаас хамгаалах хаалт, хаалга, г.м)- ийг ашиглалтын байнгын бэлэн байдалд байлгах.....	78-80
9.6. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, галын аюулгүй байдлын дүгнэлт зэргийг Орхон аймгийн Онцгой байдлын газраар батлуулах.....	80-82
9.7. Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэлтэй байх.....	82-85
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	84-93
10.1. Аюултай хог хаягдлыг бүртгэлжүүлэн хадгалах, гэрээг мэргэжлийн байгууллагатай хийж хог хаягдлыг шилжүүлэх.....	85-87
10.2. Орон нутгаас зарлаж буй бүх нийтийн цэвэрлэгээнд идэвхтэй оролцож, Чингэл гол дагуух ахуйн хог хаягдлыг түүж цэвэрлэх.....	87-88
10.3. Хог хаягдлын гэрээ хийж ахуйн хог хаягдал, уурын зуухнаас гарах үнсийг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэх, дахивар хог хаягдлыг орон нутгийн дахивар цуглуулах, тээвэр ложистикийн төвд тогтмол өгч хэвших.....	89-91
10.4. Машин техникийн үйлчилгээ, эвдрэл гэмтэл зэргээс асгаралт үүссэн дариуд бүртгэлжүүлэн саармагжуулах арга хэмжээ авах.....	91-92
10.5. Эрх бүхий байгууллагатай "Хаягдал тос" шилжүүлэх гэрээ байгуулж аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад шилжүүлэх.....	92-93
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	93-101
11.1. Агаарын чанарын хяналт шинжилгээ.....	94-96
11.2. Хөрсний чанарын хяналт шинжилгээ.....	96-97
11.3. Усны чанарын хяналт шинжилгээ.....	98-100
11.4. Бактерлогийн хяналт шинжилгээ.....	100-101
12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	101-105
12.1. Мэргэжлийн байгууллагаар Байгаль орчны аудит хийлгэх.....	101-102
12.2. Байгаль орчны мониторинг үнэлгээ хийлгэх.....	102-105
12.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний барьцаа хөрөнгө байршуулах.....	105
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	106-108
13.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг орон нутгийн ард иргэдэд тайлагнах.....	106-107
13.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хувьцаа эзэмшигчдэд тайлагнах.....	108



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

1. Төслийн талбайн ерөнхий байршил.....	2
2. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг.....	2
3. Төслийн талбайн өнөөгийн байдал.....	3
4. Хүдэр тээврийн техникүүд, технологийн замын маршрут.....	4-5
5. Нуруудан уусгах байгууламжийн талбайн зураг.....	6
6. Катодын зэс боловсруулах үйлдвэрийн талбайн зураг.....	6
7. ROAD//STABILIZR®.....	18
8. Хүдэр тээврийн 5.6км урт замд Cypher ROAD//STABILIZR® цацаж буй байдал.....	18
9. ROAD//STABILIZR®.....	19
10. Cypher дэвсэх хүдэр тээврийн технологийн замын маршрут.....	20
11. Cypher ROAD//STABILIZR® цацсаны дараах нягтруулалт.....	21
12. Уурын зуухны яндангийн утааны хэмжилт.....	22
13. Уурын зуухны яндангийн утааны шинжилгээний дүн.....	23
14. Технологийн замын усалгаа.....	24-25
15. Хаягдал бохир ус соруулж буй байдал.....	27
16. Km cable, water level meter/ газрын доорх усны түвшин хэмжигч багаж.....	27-28
17. Уснаас дээж авч, түвшин хэмжих буй байдал.....	29
18. Уст цэгүүдийн усны түвшин.....	30
19. Хяналтын цооногуудын байршил.....	31
20. Хяналтын цооногуудын усны pH (орчин).....	32
21. Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ, эрхийн бичиг.....	33-34
22. Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ.....	34-35
23. Ус ашиглалтын бүртгэл хөтөлж БОАЖГ-аар баталгаажуулав.....	35-37
24. Худгийн паспорт, цооног өрөмдөх зөвшөөрөл.....	38
25. Хүдэр тээврийн технологийн замын маршрут.....	39
26. Хүдэр тээврийн технологийн замын тэмдэг тэмдэглэгээ.....	39
27. Хотын төвд хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслийн маршрут.....	40
28. Хаягдал тос хүлээлгэн өгч буй байдал.....	43
29. Үерийн далангийн цэвэрлэгээ.....	44
30. Эвдэрсэн газрын план.....	47
31. Нөхөн сэргээлт хийхээс өмнөх болон дараах.....	48
32. Хөрс хөндөх журам.....	49
33. Асгаралт саармагжуулах элс, шохой.....	50
34. Асгаралт саармагжуулах, урьдчилан сэргийлэх журам.....	50-51
35. Үйлдвэрийн бүсийн ногоон байгууламж.....	52



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

36. Байгалийн бүс бүслүүр ба экосистем.....	53
37. Төслийн талбайн ургамлын хэв шинж.....	55
38. Мод үржүүлгийн газрын бэлтгэл ажил.....	56
39. Мод үржүүлгийн газрын талбай.....	56
40. Мод үржүүлгийн газрын талбайн бэлтгэл ажил.....	56-57
41. Мод үржүүлгийн газрын хашаа, хамгаалалт.....	57
42. Мод үржүүлгийн газрын салхины хамгаалалтын зурвас.....	57-58
43. Мод үржүүлгийн газрын үрийн нөөц.....	58
44. Үйлдвэрийн цахилгаан хангамжийн төлөвлөлт.....	59
45. Өндөр хүчдэлийн цахилгаан шугамын үзлэг.....	60
46. Үйлдвэрийн бүсэд 2023 онд хийгдсэн ногоон байгууламж.....	61
47. Үйлдвэрийн бүсэд 2023 онд хийгдсэн ногоон байгууламжийн талбай.....	61-62
48. Технологийн замын салхины хамгаалалтын зурвас байгуулсан талбай.....	63-64
49. Технологийн замын салхины хамгаалалтын зурвас, хамгаалалтын хашаа (2023 оны хавар) “Тэрбум” мод хөтөлбөр.....	64-65
50. 2023 оны намрын мод тарилт, хашаажуулалт.....	65
51. Мод тариалсан талбай /2023.10.16/.....	66-67
52. Зэс фестиваль.....	67-69
53. Малчдад зөвлөгөө өгөх, бүлгийн уулзалт.....	69-70
54. Химийн бодисын ашиглалтын тусгай зөвшөөрөл, тайлан.....	72
55. Химийн бодисын сургалт, ШУТИС.....	73-74
56. Асгаралт саармагжуулах элс, шохой.....	75
57. Ажилчдын нэг бүрийн хамгаалах хэрэгсэл.....	76-77
58. Ажилчдад олгож буй эрүүл мэнд дэмжих бүтээгдэхүүн.....	77-78
59. Үйлдвэр доторх галын автомат систем.....	78-79
60. Галын аюулгүй байдал, бэлтгэл бэлэн байдал, практик сургалт.....	79-80
61. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайлан, батлагдсан нүүр.....	80
62. Батлагдсан тайлан, төлөвлөгөө, дүгнэлт.....	81-82
63. Тусгай хэрэгцээний мэдээ.....	83-84
64. Аюултай хог хаягдлын бүртгэл гэрээ.....	86
65. Аюултай хог хаягдал хүлээлгэн өгч буй байдал.....	87
66. Бүх нийтийн цэвэрлэгээ.....	88
67. Хог хаягдлын ангилан ялгалт.....	90
68. Дахивар хог хаягдлын ангилан ялгалт, хадгалалт.....	90-91
69. Хүнд машин механизмын засвар үйлчилгээ.....	91-92
70. Автомашинуудын засвар үйлчилгээ.....	92
71. Хаягдал тос хүлээлгэн өгч буй байдал.....	93



**“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны
менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

72. Агаарын чанарын хяналт шинжилгээний цэгүүдийн байршил.....	95
73. Агаарын чанарын хяналт шинжилгээний сорьц авч буй байдал.....	95-96
74. Хөрсний чанарын хяналт шинжилгээний цэгүүд.....	97
75. Хөрсний чанарын шинжилгээний сорьц.....	97
76. Усны хяналт шинжилгээний цэгүүдийн байршил.....	99
77. Усны чанарын сорьц.....	99-100
78. Бактерлогийн шинжилгээний сорьц.....	101
79. Байгаль орчны төлөвлөгөөт аудитын тайлан.....	101-102
80. Байгаль орчны мониторинг үнэлгээний тайлан.....	102
81. БОМТ-ний барьцаа хөрөнгө-2023он.....	105
82. Нээлттэй хаалганы өдөрлөг.....	106-107
83. Хувьцаа эзэмшигчдийн хурал.....	108



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

1. Хүдэр тээвэрт ашиглах техникийн тоо, хүчин чадал.....	4
2. Нуруулдан уусгах талбайн мэдээлэл.....	6
3. Үйлдвэрийн технологийн дамжлага.....	7-8
4. Эрдэнэт станцын агаарын дундаж температур, 0C /2017-2020 он/.....	9
5. Эрдэнэт станцын сарын нийлбэр хур тунадас, мм /2017-2020 он/.....	9-10
6. Эрдэнэт станцын салхины дундаж хурд м/с /2017-2020 он/.....	10
7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсвийн нэгтгэл-2023 он.....	13-14
8. БОНБНҮ-ний зөвлөмж, 5 жилийн БОМТ-ний биелэлт.....	14-15
9. Агаарын чанарын шинжилгээний цэгүүд.....	16
10. Ажлын байрны дотоод орчинд хийгдсэн шинжилгээ.....	16-17
11. Технологийн замд Сурһег цацах ажлын тооцоо.....	20
12. Оношилгоо, үзлэгт хамрагдаж, утаа шүүгч суурилуулсан тээврийн хэрэгслүүд.....	23-24
13. Технологийн замын усалгаанд ашигласан усны хэмжээ.....	24
14. Хаягдал бохир ус зөөсөн бүртгэл 2023 оны 1-р улирал.....	25-27
15. Уст цэгийн түвшин хэмжсэн бүртгэл.....	28-29
16. Хяналтын цооногууд.....	31
17. Ус ашиглалт түүнтэй холбоотой бичиг баримтын жагсаалт.....	32-33
18. Аюултай хог хаягдлын хууль эрхзүй.....	40-42
19. ОХШ-ний сорьцын цэгүүд.....	45-47
20. Эвдэрсэн газрын бүртгэл.....	47
21. Асгаралт саармагжуулах.....	49-50
22. 2023 онд тарьж ургуулсан тарьц суулгацын тоо ширхэг.....	63
23. Асгаралт саармагжуулах.....	74-75
24. Ажилчдын эрүүл мэндийг дэмжих, хор саармагжуулах бүтээгдэхүүн.....	76
25. Талуудын мэдээлэл.....	82-83
26. Ахуйн хог хаягдал дарж устгуулсан бүртгэл.....	89
27. Агаарын чанарын хяналт шинжилгээний цэгүүд.....	94
28. Хөрсний хяналт шинжилгээний цэгүүд.....	96
29. Усны хяналт шинжилгээний цэгүүд.....	98
30. Бактерлогийн хяналт шинжилгээний цэгүүд.....	100-101



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“Зэс эрдэнийн хувь” ХХК нь 2010 оны 6 сард Орхон аймгийн 24552 хувьцаа эзэмшигчид болон “Блю Мон Металс” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар байгуулагдсан байдаг.

Манай компанийн “Байгаль орчны бодлого” нь хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулан хамгаалах, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, ард иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах эрхийг хангахад үндэслэсэн ба дараах 3 чиглэлд хэрэгжиж байна.

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- Байгаль орчны хууль эрхзүйн хүрээнд мөрдөгдөх хууль тогтоомжийн сахин мөрдөлтийг биелүүлэх
- “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн “Тэрбум мод хөдөлгөөний дэмжин оролцох” 2022/04 тоот гэрээний хэрэгжилтийг хангах.

“Зэс эрдэнийн хувь” ХХК нь Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хооронд байгуулсан 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 5/277-15 дугаартай “Исэлдсэн хүдрийн овоолго ашиглах гэрээ” байгуулан исэлдсэн хүдрийн 8а, 12 дугаар овоолгуудыг 20 жилийн хугацаанд ашиглах эрхтэй гэрээ байгуулан Эрдэнэт үйлдвэрийн “Эрдэнэ-Овоо” ордын хаягдал овоолгын исэлдсэн хүдрийг HL-SH-EW (Нуруулдан уусгах шүлтгүйжүүлэлт-уусган хандлалт, цахилгаан химийн арга) АНУ-ын технологийг Монгол орны нөхцөл байдалд тааруулан катодын зэсийн үйлдвэрийг байгуулахаар бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна. Тус төсөл хэрэгжсэнээр шинээр 437 ажлын байр /ТЭЗҮ-ийн тодотгол тайлан-2021он/ бий болж улс орон нутгийн төсөвт 23-25тэр бум төгрөгийг жилд төвлөрүүлэхээс гадна дотоодын аж ахуй нэгжүүдээс жилдээ 30 тэр бум орчим төгрөгийн худалдан авалт хийнэ. Монгол улсад 52 сая долларын валютын урсгал бий болгож цаашлаад “Катодын цэвэр зэсийн үйлдвэр”-ээс “Зэс боолтын үйлдвэр”, “Зэс эрдэнийн хотхон” орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байгаа юм.

1.1. Төслийн зорилго

Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр”-ийн агуулга багатай исэлдсэн хүдрийн овоолго /8а, 12/-с уусган хандлалтын /нуруулдан уусгах шүлтгүйжүүлэлт-уусган хандлалт, цахилгаан хими/-ийн аргаар катодын цэвэр зэс үйлдвэрлэн гадаад зах зээлд нийлүүлэх, цаашид дэвшилтэт технологи ашиглан үр ашигтай үйлдвэрлэлийг өргөжүүлэх ингэснээрээ үндэсний үйлдвэрлэл, дотоодын бүтээгдэхүүний нөөц төрлийг нэмэгдүүлэх экспорт болон валютын нөөцийг өсгөх, шинээр ажлын байр бий болгож Орхон аймгийн ард иргэдийн тогтвортой ажлын байраар хангах, улс орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого төвлөрүүлэн Монгол улсын нийгэм, эдийн засагт хувь нэмрээ оруулахад энэхүү төслийн зорилго оршино.




“Ээс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан


1.2. Төслийн байршил

Орхон аймаг Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг Сархиа уулын зүүн энгэр Эрдэнэт үйлдвэрийн бүсэд хамаардаг. Төслийн талбай нь Улаанбаатар хотоос 380км, Орхон аймгийн төвөөс 8 км зайд уртрагийн 104, өргөргийн 48⁰ градуст, далайн түвшнээс дээш 1300метрт байршиж байна. Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны 10 сарын 04-ний өдрийн А/197 тоот захирамж, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай байгуулсан 2021 оны 12 сарын 12-ны өдрийн 5/270-21 тоот “Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглуулах гэрээ”-ний дагуу үйлдвэрлэлийн зориулалттай 1068484м² талбайг 15 жилийн хугацаатай эзэмшиж байна.

Зураг-1. Төслийн талбайн ерөнхий байршил



Зураг-2. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг





*“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан
Зураг-3 Төслийн талбайн өнөөгийн байдал*



1.3. Төсөл хэрэгжүүлэх үндсэн суурь нөхцөл

Эрдэнэтийн-Овоо ордыг анх 1963 онд Чех, Монголын геологичид нээж, ордод хайгуулын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд үргэлжлүүлэн Зөвлөлт холбоотын улсын геологичид орд газрын нарийвчилсан хайгуулын ажлыг хийж дуусгасан байдаг. 1972 онд “Эрдэнэтийн-Овоо”-ны зэс, молибдены ордыг ашиглах Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж баталсан ба 1973 оны 02 дугаар сарын 20-нд ордыг ашиглах талаар БНМАУ, ЗСБНХУ-ын засгийн газар хооронд түүхэн хэлэлцээр байгуулагдсан. “Зэс эрдэнийн хувь” ХХК нь Орхон аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, “Эрдэнэ үйлдвэр” ХХК-тай 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан “Исэлдсэн хүдрийн овоолго ашиглах гэрээ”-г байгуулан УБЭҮ-н 8а болон 12-р овоолгыг ашиглан гидрометаллургийн аргаар катодын цэвэр зэс боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн.

“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн “Зэс боловсруулах үйлдвэрийн төсөл”-д ашиглах хүдрийн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн №15-01-06 тоот дүгнэлт, Ашигт малтмалын газрын даргын 2015 оны 02 дугаар сарын 26-ний өдрийн №Т/21 тушаал, Үндэсний геологийн албаны даргын 2022 оны 09 дугаар 06-ны өдрийн Н-72 тоот “Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай” тушаал, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн СТР-02-04 тоот дүгнэлт”-ээр тус тус нөөцийг хүлээн авсан байдаг.



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Тус үүсмэл ордын ашиглалтын явцад 12 жилийн хугацаанд овоолго тээвэрлэх процесс үргэлжилнэ. Шимт уусмал боловсруулах үйлдвэр нь 12 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулахаар төлөвлөгдсөн бөгөөд жилд 10.0 мян.тн 99.99 %-ийн цэвэршилттэй катодын зэс үйлдвэрлэнэ. Үйлдвэрийн 1 тн катодын зэсийн бүрэн өөрийн өртөг 9.3 сая төгрөг байна. Эдгээрээс харахад энэхүү төсөл хэрэгжиж эхэлснээр улс, орон нутгийн төсөвт багагүй хувь нэмэр оруулах бөгөөд жилд дунджаар 57.4 тэрбум төгрөг, төслийн хугацаанд нийт 746.1 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсөвт татвар төлбөр хэлбэрээр төвлөрүүлнэ.

1.4. Хүдэр тээвэрлэх процесс

Хаягдал овоолгоос хүдэр зөөх - Хаягдал овоолгуудыг ил уурхайн аргаар түвшин бүрээр нээж ашиглахаар төлөвлөсөн. 8а, 12-р овоолгуудаас зөөх хүдрийн хэмжээ зэсийн дундаж агуулгаас хамаарч 4.7-3.4 сая.тн байна. Хүдэр зөөх жилийн хүчин чадал 1-3-р жилүүдэд 4.7 сая.тн/жил-ээр, 4-12-р жилүүдэд 3.4 сая.тн/жил ба 8а овоолгоос түрүүлж хүдрийг зөөж эхлэх бөгөөд 4-р жилд 12-р овоолгыг зөөнө.

Хүснэгт-1. Хүдэр тээвэрт ашиглах техникийн тоо, хүчин чадал


№	Төрөл	Зориулалт	Марк	Тоо
1	Экскаватор 6.7м ³	Хүдэр олборлолт	Hyundai R 1250LC	1
2	Экскаватор 3.2м ³	Хүдэр олборлолт	Hyundai R 520LC	1
3	Автосамосвал 60тн	Хүдэр тээвэр	MT86	12
4	Бульдозер 38тн	Овоолго мөргөцөг, хүдэр бэлтгэлд	Shantui SD32W	2
5	Утгуурт ачигч 7м ³	Бутлуур	Luigong 8128H	1
6	Автосамосвал 60тн	Бутлуур	Howo	2
7	Автогрейдер 4.2м	Технологийн зам талбайн засвар	SMG230C-8	1
8	Хөнгөн тээврийн хэрэгсэл	Хүн тээвэр	TOYOTA Land Cruiser 76	3
9	Гэрэлт цамхаг, 32000м ³	Гэрэлтүүлэг	APOLO AS4006	2
10	Усны машин 20м ³	Зас усалгаа	SINOTRUK-HOWO CLY525GSS	1

Зураг-4. Хүдэр тээврийн техникүүд, технологийн замын маршрут





“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



1.5. Үйлдвэрийн технологийн процесс

Овоолго ашиглалтын 12 жилийн хугацаанд 8а, 12-р овоолгоос 42.91 сая.тн хүдрийг 2 нуруулдан уусгах овоолго үүсгэж, уусгалтыг явуулна.

Хүдэр нуруулдан уусгах: Нуруулдан уусгалт нь уусгалт явуулах байгууламж, уусмал цуглуулах шугам сан, уусмал шахах насос станцуудаас бүрдэнэ. Нуруулдан уусгах байгууламжид нуруулдсан хүдрийг зуны улиралд бороожуулах систем ашиглан хүхрийн хүчлийн сулруулсан уусмалаар $850 \text{ м}^3 / \text{цаг}$ хүчин чадалтайгаар $D_n=400$ мм-ийн параллель HDPE хоолойгоор 1.5 мПа хүртэл даралттайгаар шахаж хүдрийг уусгана. Шимт уусмалыг 400 мм HDPE CPE хоолойгоор цуглуулан тунгаах санд тэжээнэ. Хүдэр нуруулдан уусгах талбайн суурь болон уусмал алдагдах, цуглуулах зорилгоор тусгай зориулалтын геотекстил, геомембран дэвсгэрийг дэвсэж, нуруулдсан хүдэрт бороожуулах системээр хүхрийн хүчлийн уусмалыг өгнө. Хүдэр уусгалтын процесс 365 хоногийн турш тасралтгүй үргэлжилнэ. Уусгалт явуулах талбайд хүхрийн хүчлийн сулруулсан уусмалаар уусгалт явуулж эхэлснээс хойш 7-14 хоногийн дараа зэс агуулсан шимт уусмал PLS



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

/pregnant leach solution/ гарч эхэлнэ. Уусгалт нэг талбайд 60-90 хоног явагдана. Энэ нь хүхрийн хүчлийн уусмал исэлдсэн хүдрээр нэвчин өнгөрөхдөө хүдэр дэх зэсийн эрдсүүдийг уусгаж авах процесс юм

Хүснэгт-2. Нуруулдан уусгах талбайн мэдээлэл

№	Байгууламж	Талбайн хэмжээ	Өндөр	Хүчин чадал
1	Нуруулдан уусгах байгууламж Sell-1	13.6га/498м*280м/	40м	5.2сая.тн хүдэр
2	Нуруулдан уусгах байгууламж Sell-2	41.75га/840м*487м/	110м	37.6сая.тн хүдэр
Нийт				42.9 сая.тн хүдэр

Зураг-5. Нуруулдан уусгах байгууламжийн талбайн зураг



Зураг-6. Катодын зэс боловсруулах үйлдвэрийн талбайн зураг





“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Төслийн талбайд хаягдал овоолгоос зөөвөрлөсөн хүдрийг нуруулдан уусгах овоолгод буулгасны дараа хүдэр нуруулдан уусгах процесс эхэлнэ.

Уусмал цуглуулах систем: Нуруулдан уусгах байгууламжийн суурийн геомембран доторлогооны дээр уусмал цуглуулах хоолойг угсарна.

Шүүрэлт хянах систем: Тус систем нь нуруулдан уусгах байгууламж болон уусмалын сангуудаас газрын гүнд химийн бодис, хаягдал нэвчихээс сэргийлдэг ба геомембран дэвсгэрийн доор 30 см-ийн гүнд байрлана.

Уусмалын сангууд: Төслийн талбайд үндсэн 5 төрлийн сан байх ба үүнд тунгаах, шимт уусмал, үйлдвэр тэжээх, ядуу уусмалын, аваарын сангууд багтана. Эдгээр сангууд **/нийт 51 300 м³ эзлэхүүнтэй/** нь нуруулдан уусгах байгууламжийн урд байрлах ба цагт өгөх уусмалын хэмжээ нь дунджаар 850.0м³ юм.

- Тунгаах сан – 973.0 м³
- Шимт уусмалын сан – 25600.0 м³
- Үйлдвэрийн тэжээлийн сан – 6550.0 м³
- Ядуу уусмалын сан – 9100.0 м³
- Аваарын сан – 9100.0 м³

Үйлдвэрийн технологийн дамжлага: Шимт уусмалын сангаас HL-SH-EW (Нуруулдан уусгах шүлтгүйжүүлэлт-уусган хандлалт, цахилгаан химийн арга)-аар катодын цэвэр зэсийг гаргаж авах юм.

Хүснэгт-3. Үйлдвэрийн технологийн дамжлага

№	Дамжлага	Зориулалт	Хүчин чадал	Тайлбар
1	Үндсэн хандлалт /Хандлагч-1/	Шимт уусмал дахь зэсийг органикаар хандалж, эргээд органикаас сулруулсан хүхрийн хүчлээр урвуу хандалж электролизд тохиромжтой электролит уусмал гарган авах	780-850 м ³ /цаг шимт уусмал, 820-900м ³ /цаг органик хандлагч	Хандлагч 1-ээс гарсан ачаалагдсан органик фаз урвуу салгалт руу, урвуу хандлалтаас гарсан шингэрсэн органик фаз давтан хандлагч руу орно
2	Жигд усан фаз	Усан фаз дотор органик фаз жижиг дусал хэлбэртэй байх тул катодын чанарыг муутгахаас сэргийлж усан фаз жигд тасралтгүй шинжтэй байх ёстой		
3	Гүйцээх хандлалт /Хандлагч-2/	Хандлалт-1-с орж ирсэн уусмалаас зэсийг хандлалт-2 хандлахдаа ядуу органикийг ашиглана		Зэсгүйжсэн усан фаз буюу ядуу уусмал нуруулдан уусгах байгууламж руу шахагдана.
4	Шимт уусмалын халаалт	Хүйтний улиралд органик фак дах зэсийн агуулгыг нэмэгдүүлэх		Шимт уусмалыг үндсэн хандлагч руу орох шугам дээр 10-14°C хүртэл халаана.
5	Угаах ажиллагаа	Ачаалсан баян органикт баяжсан бусад	Угаах шингэний рН 2.0 байх ба	Төмөр, марганц, хлор зэрэг элементүүдийн



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

		элементүүдийн ионыг зайлуулах	тасралтгүй эргэнэ.	ионоор баяждаг.
6	Урвуу хандлалт	Хандлалт-1-ээс ирсэн баян органик ба цахилгаан химийн цехээс ирсэн ядуу электролитээс зэсийг баяжуулах	4.77 г/л зэс агуулсан 450 м ³ органик, 180 г/л хүхрийн хүчил, 35 г/л Cu ²⁺ агуулсан 110 м ³ ядуу электролит орно	Зэсээ алдаж ядуурсан органик хандлагч 2-руу өгөгдөнө.
7	Баян электролитийн цэвэрлэгээ	Баян электролитийг электролизид оруулахаас өмнө органикийн агуулгыг шалгах	Электролитэд органик нэгдлийн агуулга 10 ppm-ээс бага байх шаардлагатай	Кобалтын сульфат, гуартекийн давирхай нэмж зэсийн чанарыг сайжруулна. Бусад элементүүдийг угаана.
8	Баян электролитийн халаалт	Цэвэрлэгдсэн баян электролит уусмалыг уураар халаах	42 ⁰ C– 44 ⁰ C хүртэл халаана.	
9	Электролизийн ванн	Катодын зэс үйлдвэрлэх	Хоногт 29-31 тн орчим катодын зэс гарна	Хүчилд тэсвэртэй, 6.2 м урт, 1.4 м өргөн, 1.5 м өндөртэй 54 катод, 55 анодтай ванн суурилуулна.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Байгалийн мужлал

Байгалийн нөхцөлөөрөө ерөнхий нэг төрх байдалтай бөгөөд зэргэлдээх нутгаасаа байгалийн тодорхой шинжээр зааглагдсан нутгийг байгаль газарзүйн их муж гэж нэрлэнэ. Монгол орны байгалийн мужлалаар Хангай Хэнтийн уулархаг их мужийн хээрийн мужид багтана. Хангай Хэнтийн уулархаг их мужийн хил нь газарзүйн байрлалын хувьд ойт хээрийн бүсийн хилтэй тохирно. Манай орны нутгийн төв хэсэгт баруун, баруун урд, зүүн талаараа Говь-хээрийн талархаг, Алтайн уулархаг их мужтай хиллэн оршино. Хангайн уулын муж нь Хэнтийн уулын мужаас Туул, Орхон голын хөндийгөөр, Хөвсгөл орчмын уулын мужаас Тэсийн гол, Бүгсэй голын хөндийгөөр тусгаарлагдана. Байгалийн мужлал хүрээлэн буй газарзүйн орчин өөр хоорондоо адил биш, газрын гадаргын хэлбэр, уур амьсгал, ус, хөрс, ургамал, амьтны аймаг нь янз янз байдаг.

2.2. Газар зүйн байрлал, газрын гадарга

Орхон аймаг нь Монгол улсын төв хойд хэсэгт оршдог бөгөөд Сэлэнгэ, Булган аймагтай хиллэн оршдог. Далайн түвшнээс дээш 1200 метрт өргөгдсөн 84.4 мянган га газар нутагтай. Улаанбаатар хотоос ойролцоогоор 380км зайд орших бөгөөд засмал болон төмөр замаар нийслэл хоттой холбогдсон байдаг. Нийт нутаг дэвсгэрийн 50.2 мянган га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 25.1 мянган га нь хот тосгоны суурин газар, 24.7 мянган га нь ойн сан бүхий газар багтдаг. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 5300 га нь тариалангийн талбай, 33700 га нь бэлчээр юм.

2.3. Цаг уур, уур амьсгал



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Уур амьсгал бол тухайн газар нутагт цаг агаар урт удаан хугацааны туршид тогтож ирсэн цаг агаарын дундаж нөхцөл байдал юм. Уур амьсгалын өөрчлөлт гэж уур амьсгал байгалийн жам ёсоороо хэлбэлзэх хугацааны туршид хүний шууд болон шууд бус үйл ажиллагааны улмаас дэлхийн хийн мандлын бүтцэд гарч байгаа өөрчлөлтийн дүнд бий болсон өөрчлөлтийг хэлнэ.

Агаарын даралт: Станцын түвшин дэх агаарын даралтын сарын дундаж утга 869.0-869.1 г/Па, хамгийн их даралт нь 891.0-891.5 г/Па, хамгийн бага нь 850.9- 851.3. г/Па хооронд хэлбэлздэг.

Агаарын температур: Агаарын температурын олон жилийн дундаж 0,8С, агаарын температурын хамгийн их утга нь 1999 онд 39.0 С хүрч халсан, агаарын температурын хамгийн бага утга нь 2001 онд – 40.0 С хүрч хүйтэрсэн байна.

Хүснэгт-4 Эрдэнэт станцын агаарын дундаж температур, °С /2017-2020 он/

Станц	Он	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ЭРДЭНЭТ	2017	-16.2	-11.3	-4.3	5.4	12.0	17.7	19.5	15.3	9.4	0.9	-9.2	-12.9
	2018	-19.1	-14.7	-2.8	4.3	12.2	17.0	16.5	16.3	8.3	3.3	-8.0	-17.4
	2019	-15.2	-16.2	-2.3	4.2	8.7	16.7	18.3	15.7	13.1	1.1	-9.2	-13.5
	2020	-13.5	-11.4	-3.8	6.8	10.3	16.1	17.6	15.3	10.2	0.7	-6.4	

Агаарын чийгшил: Харьцангуй чийгийн олон жилийн дундаж нь 62% байна.

Уур амьсгалын улирлын шинж чанар: Нарны цацрагийн жилийн явцаас хамааран сэрүүн бүсэд жилийн дөрвөн улирал ээлжилдэг. Тухайн орон нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын шинж зэргээс хамааран улирлын шинж газар бүр харилцан адилгүй байдаг. Уур амьсгал бол тухайн газар нутагт цаг агаар урт удаан хугацааны туршид тогтож ирсэн цаг агаарын дундаж нөхцөл байдал юм. Орхон аймаг нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар ойт хээрийн бүст Хангай нурууны салбар уулс Бүрэнгийн нурууны өвөрт Орхон, Сэлэнгийн сав газарт далайн түвшнээс дээш 1300м-н өндөрт оршдог. Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай боловч газарзүйн байршлаасаа шалтгаалан дулааны улиралд сэрүүвтэр, хүйтний улиралд харьцангуй дулаавтар, хавар намрын улиралд салхи шуурга ихэсч хуурайшилтын зэрэг, агаарын температурын хэлбэлзэл өсөж, тогтворгүй болдог.

Хур тунадас: Жилийн нийлбэр тунадасны олон жилийн дундаж нь 360,7мм ба үүнээс дулааны улиралд 326,3 мм, хүйтний улиралд 34,4 мм нь ордог байна. Хамгийн их тунадас нь 2012 оны 7-р сард 274,6 мм тунадас орсон байна.

Хүснэгт-5. Эрдэнэт станцын сарын нийлбэр хур тунадас, мм /2017-2020 он/

Станц	Он	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	2017	2.1	5.8	9.6	16.0	24.3	40.3	50.5	119.3	49.4	8.7	34.5	4.7
	2018	4.1	5.4	4.1	14.9	6.0	61.5	107.5	119.0	79.7	18.0	3.8	3.8



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ЭРДЭНЭТ	2019	2.8	0.2	1.8	4.4	24.7	41.9	49.7	42.8	18.6	28.5	10.2	3.9
	2020	1.9	3.6	3.6	0.9	24.6	57.9	87.9	94.6	42.9	4.9	3.6	

Хүснэгт-6. Эрдэнэт станцын салхины дундаж хурд м/с /2017-2020 он/

Станц	Он	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ЭРДЭНЭТ	2017	1.7	1.9	1.8	2.4	2.6	2.3	2.4	2.5	2.6	2.4	2.5	2.0
	2018	2.0	2.2	2.4	3.1	3.0	2.6	2.2	1.9	2.6	2.6	2.6	2.0
	2019	2.0	2.0	2.6	2.9	3.1	2.5	2.5	2.1	2.3	2.9	2.5	2.1
	2020	2.0	2.1	3.2	2.8	3.2	2.7	2.5	2.5	2.1	2.8	2.2	

2.4. Гадаргын ба газрын доорх усны өнөөгийн төлөв байдал

Орхон аймгийн нутаг дэвсгэрт газрын доорх усны нөөц бага боловч гадаргын усан сүлжээ жижиг гол горхи элбэгтэй. Талбайн ойр орчмын усан сүлжээний гол хагалбар нь Хөх чулуутын нуруу, Дөрвөн хөхөөтийн нуруу, Бүрэн бүстийн овоо, Дэлэнгийн даваа юм. Гадаргын урсацтай гол горхийг нэрлэвэл Хангал гол, Орхон гол, Эрдэнэт гол, Чингэлийн гол, Зуны гол, Урт булаг зэрэг болно. Бүрэн бүстийн овооны баруун урд бэлээс Чингэлийн гол эх авч зүүн тийш урсан, Дөрвөн хөхөөтийн нурууны хойноос эх авч урсах Ивээлт гол, урд бэлээс эх авч урсах Зүйлийн гол, Дэлэнгийн давааны зүүн хажуугаас эх авч урсах Тал булгийн горхитой нийлэн урагш урсаж Орхон голд цутгадаг. Эдгээр гол горхи нь байгалийн цас бороо, түр зуурын үерийн ус болон булаг шандын усаар тэжээгддэг цэнгэг устай, түргэн урсацтай голууд юм. Эрдэнэтийн голын сав газрын 9.2 хувь буюу 9.1 ам км, Говил голын ус хурах талбайн 33.8 хувь буюу 20.6 ам км, Зуны голын сав газрын 30.1 хувь буюу 26.6 ам км талбайд навчит, холимог, шинэст ой тархан усны горимд байгалийн зохицуулах нөлөө үзүүлж байна. Эрдэнэтийн болон Говил голоос харьцангуй бага урттай боловч Хангал голын урсцын 50 гаруй хувийг эзлэх Зуны гол Хангал голын эх болно. Өмнөх судалгааны үр дүнгээс үзэхэд тухайн бүс нутагт усан сүлжээний гадаргын урсцын модуль 2.1 л/сек.км² ба тэдгээрийн нөхөн сэлбэгдэх, үндсэн тэжээлийн хангалтыг агаарын хур тунадас зонхилон гүйцэтгэдэг бөгөөд нэлээд хязгаарлагдмал байдлаар газрын доорх ус хам хэлбэрээр нэмэлт тэжээлийг өгнө. Эрдэнэт гол, Говил гол, Зуны голууд нь Орхон голын баруун цутгалан болох Хангалын голын ай савд хамрагдана.

2.5. Хөрсөн бүрхэвчийн өнөөгийн төлөв байдал

Судалгааны талбай байрлаж буй хэсэг нь Орхон аймгийн Баян-өндөр сумын нутагт хамаарагдана. Төсөл хэрэгжих бүс нутаг нь дундаж өндөр уул, уулын хээрийн хэв шинжийн хөрс, хөрсөн бүрхэвч тархсан бөгөөд гадаргын төрх байдлын хувьд уулын хэв шинж, тэдгээрийн хоорондох өргөн бэл, хөндийн гадаргатай. Хөрс газарзүйн мужлалын хувьд Хангайн их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн хүрээнд Хангайн мужийн Хангайн зүүн хөрсний тойрогт хамаарагдаж байна. (Монгол улсын үндэсний атлас, 2009 он) Төслийн үйл ажиллагааны хүрээнд өдрийн ажиглалт, судалгаа явуулсан бөгөөд хээрийн судалгааны ажлаар тухайн 2 цэгээс хөрсний үржил шимт шинж чанар, механик бүрэлдэхүүн, хөрсний хүнд металлын бохирдол



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

тодорхойлуулахаар 2 ширхэг хөрсний дээжлэлт авсан болно. Төслийн талбай нь хот суурингийн эвдэрсэн хөрсний хэв шинжид хамаарч байна.

2.6. Ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдал

Эрдэнэт хот орчмын ургамлан бүрхэвчийн ургацын өөрчлөлтийг тодорхойлох зорилгоор Зайнаас тандан судлах аргаар Ландсат-5 болон Ландсат-8 хиймэл дагуулуудыг 1996 оноос 2020 он хүртэл 5 жилийн давтамжтай мэдээнүүдийг ашиглан NDVI буюу Ургамлын ногоорлын нормчилсон индекс бодуулав. Том масштабын байр зүйн зураг (1:100 000), монгол орны ургамалжилтын суурь зураг (1:1 000 000) зургуудыг ашиглан талбайн ургамалжилтын зургийг урьдчилсан гаргаж, хээрийн судалгаагаар ургамалжилтын хэв шинжийг баталгаажуулсан. Ургамлын өөрчлөлтийг хөрсөн бүрхэвчийн өөрчлөлттэй уялдуулах зорилгоор хөрсний мониторинг хийсэн цэгүүдтэй ижил цэгт хийсэн болно. **Ургамлын бүлгэмдэл:** Ленийн ботууль-уулалж-навтуулт хээр. **Ургамал бүрхэвч:** 90-95% **Хагдан бүрхэвч:** 0 Сөөгөн бүрхэвч: 0 Нэгж талбайн ургац: 2-3ц/га Ургамалшлын өнгө, нийтлэг шинж, тусгаг бүрхэц: Цайвар шаргал өнгөтэй, хатаж хагдарсан, талхлагдаж доройтсон. **Газрын гадаргуу:** Урагш 2-3⁰ хэвгий, ерөнхийдөө хөрс суларч, шороо урвасан. Ашиглалт, усан хангамж: Малын бэлчээр, машин замын ойролцоо ихтэй. **Хөрс:** Хээрийн хар хүрэн хөрс, хуурай, бутрамтгай. Зүйлийн бүрэлдэхүүний хувьд харьцангуй олон боловч талхалж доройтуулан ургамлын өндөр 2-3см байна. Нийт төслийн талбайн 80 % -д ургамлан нөмрөггүй буюу ургамлан нөмрөг талхлагдсан байна.

2.7. Амьтны аймгийн өнөөгийн төлөв байдал

Эрдэнэт хот орчим болон тухайн орон нутагт 36 зүйлийн хөхтөн амьтан бүртгэгдсэн байна. Тэдгээрээс ховордож буй 2 зүйл, 15 зүйлийн ховор, ердийн 17 зүйл, олон тоотой 2 зүйл байгаа бөгөөд 21 зүйл нь ойн, 19 зүйл нь хээрийн, 19 зүйл нь нугын биотопын амьтад байна. Хотжилтын нөлөөгөөр дагуурын огдой, бор туулай, урт сүүлт зурам, тарвага зэрэг амьтад идэш тэжээлийн дасал болсон газраасаа шахагдан гарсан байна. Хүний шууд бус үйл ажиллагаа, хулгайн ангийн нөлөөгөөр агнуурын ач холбогдол бүхий хөхтөн амьтдын тоо толгой цөөрч болзошгүй. Түүнчлэн тухайн үйлдвэрийн бүс нутагт үргэн зайлах зэрлэг амьтад, шувуу байхгүй тул амьтдын амьдрах орчин нөхцөлд өөрчлөлт орохгүй юм. Эрдэнэт хот байгуулагдан хотжилтын нөлөө явагдсанаас амьтны аймагт багагүй өөрчлөлт орж зарим синантроп зүйлийн амьтад үзэгдэх болжээ. Тухайлбал, хон хэрээ, улаан хошуут, сохор элээ, хөхвөр тагтаа г.м. Хангал, Чингэл зэрэг голуудад сахалт жараахай-сибирийн хадран зэрэг байх бөгөөд загасны ангийн төлөөлөгчид энэ нутагт зүйлийн бүрдлээр бага юм. Хоёр нутагтан, мөлхөгчид амьтад харьцангуй бага судлагдсан бөгөөд монгол бах өргөн тархалттай төдийгүй хотын парк, ногоон зүлэгтэй хэсэгт ч тааралдана. Мөлхөгчдийн ангийн төлөөлөгчдөөс монгол гүрвэл, зулзагат гүрвэл, бамбай хоншоорт могой тархаж байна гэж бүртгэгджээ. Бамбай хоншоорт могой нь уулын хээр болон нугаар дайралдах бөгөөд жижиг мэрэгчид, шулуун далавчтанаар хооллодог, хор нь хүчтэй нөлөөтэй байдаг. Тус нутгийн шувууны ангийн төлөөлөгчид харьцангуй сайн судлагдсан бөгөөд хотжилтын нөлөө синантроп зүйлийн шувуудад эерэг нөлөөтэй байна. Тус нутагт 110 зүйлийн шувуу бүртгэгдсэнээс (Болдбаатар, 1997) 36 зүйл нь жилийн туршид амьдардаг тухайн нутгийн, 74 зүйл нь суурьшмал бөгөөд тэдгээрээс



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

103 зүйл нь үүрээ засдаг шувууд байна. Тэдгээрийг идэш тэжээлийн орчны шинжээр нь ялгавал ихэнх нь (ойролцоогоор 80 зүйл) мод-сөөгөн биотопод хамрагдана. Хээрийн биотопод 18 зүйл, өндөр уулын 1 зүйл, чулуурхаг биотопийн 3 зүйл байна. Хамгийн олон тоотой шувуудаас: ангир, сохор элээ, хөхвөр, хадны, урацай, адууч чогчоохой, шаазгай, улаан хошуут, хон хэрээ, хээрийн бор шувуу зэрэг байна. Эдгээрээс 7 зүйл нь синантроп зүйл байна. Тус нутагт 34 зүйлийн ховор, нэн ховор болон ховордож байгаа 10 зүйлийн шувуу байна. Гэвч тус нутагт ховор шувууд нь монгол орны хувьд нэн ховор шувууд биш юм.

2.8. Нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал

Орхон аймаг нь газарзүйн байрлалын хувьд Монгол улсын төв хойд хэсэгт оршдог бөгөөд Сэлэнгэ, Булган аймагтай хиллэдэг. Далайн түвшнээс дээш 1200 метрт өргөгдсөн, 84,4 мянган га газар нутагтай. Газар нутгийн 50,2 мянган га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 25,1 мянган га нь хот, тосгоны суурин газар, 24,7 мянган га нь ойн сан юм. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 5300 га нь тариалангийн талбай, 33700 га нь бэлчээрийн газар байна. **Хүн ам, өрхийн мэдээлэл:** 2020 оны 12 сарын байдлаар хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн санд Орхон аймгийн харьяат 108.7 мянган хүн 28.6 мянган өрхөд бүртгэлтэй байна. Суурин хүн амын 59.7 хувь нь 16-59 насныхан, 32.5 хувь нь 0-15 насныхан, 7.8 хувь нь 60 ба түүнээс дээш насныхан байна. Эрүүл мэнд: Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн 82 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 8 нь өрхийн эрүүл мэндийн төв, 69 нь хувийн эмнэлэг байна. **Мал аж ахуй:** Жилийн эцсийн мал тэжээвэр амьтдын тооллогоор 910 малчин өрхөд 137.0 мянган толгой мал тоологдов. Өмнөх оноос малын тоо 7.9 хувиар, малчин өрх 9.0 хувиар, малтай өрх 8.0 хувиар нэмэгдсэн байна. Нийт малчдын 56.8 хувь нь 35-60 насны, 22.6 хувь нь тэтгэврийн насны, 20.6 хувь нь 16-34 насны малчид ба эдгээрийн 40.5 хувь нь эмэгтэйчүүд байна. **Газар тариалан:** Хаврын тариалалтаар 3940.0 га-д үр тариа (үүнээс 3890.0 га-д улаан буудай), 365.7 га-д төмс, 372.5 га-д хүнсний ногоо, 59.2 га-д малын тэжээл, 7.0 га-д даршны ургамал, 60.0 га-д техникийн ургамал, 4.0 га-д жимс жимсгэнэ тариалсан нь үр тарианы хувьд төлөвлөгөөт зорилт 112.6 хувь, төмс 106.6 хувь, хүнсний ногоо 119.0 хувь, малын тэжээл 29.6 хувь, жимс, жимсгэнэ 26.8 хувьтай биелжээ. **Худалдаа үйлчилгээний салбар:** 2019 оны жилийн эцсийн байдлаар худалдаа, нийтийн хоолны 689 цэг салбар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 129.8 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийж, нийт бараа гүйлгээ өмнөх оноос 13.7 хувиар нэмэгдсэн байна. Бүртгэлтэй аж нэгж байгууллага: 2020 оны байдлаар Орхон аймагт 5161 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаа ба өмнөх оноос 4.7 хувиар буюу 231-ээр нэмэгдсэн байна.

2.9. Орон нутгийн иргэдийн нийгэм-эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл

Төслөөс орон нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжилд дараах чиглэлээр эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтой юм.

- Төслийн хэрэгжилтийн үед төлөгдөх татварыг орон нутгийн төсөвт хуримтлуулах замаар эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлэх
- Төсөл хэрэгжилтийн үед татвар хураамж, НДШ, орлогын албан татвар зэрэг МУ-ын үндсэн хууль болон бусад холбогдох хууль дүрэмд тусгагдсан татваруудыг төлөх замаар орон



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

нутгийн төсөвт хувь нэмэр оруулах боломжтой

- Орон нутгийн иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулах, ажлын байраар хангах замаар амьжиргааны түвшин, нийгэм-эдийн засгийн салбарт дэмжлэг үзүүлэх
- Орон нутгийн хувьцаа эзэмшигч 24,522 иргэдэд жил бүр ногдол ашгийг хувийг тарааснаар иргэдийн амьжиргаанд нэмэр оруулах

2.10. Түүх соёлын өвийн өнөөгийн төлөв байдал

Төслийн талбайд түүх соёлын өв илэрвэл Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хуульд заасны дагуу мэргэжлийн байгууллагад хандан судалгаа, шинжилгээ, малталтын дүн болон палеонтологи, археологийн олдворыг сумын захиргаанд тайлагнана. Сумын засаг дарга нь судалгаа, хайгуул, малталт хийсэн газрыг хариуцна. Тэдгээр түүх, шинжлэх ухаан, соёлын үнэт зүйл болох газар, хөрс нь улсын хамгаалалтад байх бөгөөд олдвор нь улсын өмч болдог. Археологи ба палеонтологийн үнэт дурсгалт зүйлс нь аль болох байгалийнхаа байсан газарт нөөцлөгдөн хадгалагдах зарчимтай гэж хуульд заасан байдаг.

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам /Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2-р хавсралт/, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан “Байгаль орчны төлөв байдлын тайлан”, “Байгаль орчны төлөвлөгөөт аудитын тайлан”, “Газрын төлөв байдал чанарын хянан баталгааны тайлан”-г үндэслэн **“БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН БАТЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ”** /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт/ зэрэг бичиг баримтуудыг удирдлага болгон түүнтэй холбогдсон харилцааг хуулийн хэм хэмжээнд хэрэгжүүлэн ажиллах байгаль орчинд үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагад нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэн ажиллав.

“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-нд заагдсан дараах 10 төлөвлөлтийн дагуу 73 ажил нийт 84,384,053.00 /Наян дөрвөн сая, гурван зуун наян дөрвөн мянга, тавин гурав/ төгрөг төлөвлөв.

Хүснэгт-7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсвийн нэгтгэл-2023 он

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Мөнгөн дүн/төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	29,621,620.00
2	Нөхөн сэргээлт	12,752,154.00
3	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	15,752,154.00
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	1,000,000.00
6	Химийн бодисын осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	6,265,000.00
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	8,903,125.00
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	7,550,000.00
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2,540,000.00
10	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
Нийт дүн		84,384,053.00

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн “Катодын зэс боловсруулах үйлдвэр”-ийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахдаа үүсэж болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх нөхцөл, боломжийг бодитоор тооцоолон БОНБНУ-ний тайланд тусгагдсан зөвлөмж, холбогдох дүрэм журам стандартуудыг мөрдөн хэрэгжилтийг хангаж ажиллав. Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулахад Монгол улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомжууд болон бусад хууль эрхзүйн баримт бичгүүд, төрийн байгууллагын тушаал шийдвэр, шаардлагыг биелүүлэхээс гадна үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн явуулахад өдөр тутмын хэрэгцээнд мөрдөх тулгуур баримт бичиг, журмуудыг боловсруулан мөрдөж ажиллав.

БОНБНУ-ний тайланд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжийн биелэлт 51.79 хувьтай хэрэгжсэн ба 5 жилийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний биелэлт 72.08 хувьтайгаар биелсэн байна.

Хүснэгт-8. БОНБНУ-ний зөвлөмж, 5 жилийн БОМТ-ний биелэлт

№	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны нэр	Төлөвлөсөн	Биелсэн	Гүйцэтгэл (%)
Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ				
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	30	12	40.00
2	Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	13	8	61.54
3	Хөрсний чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	15	7	46.67
4	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	5	3	60.00
5	Ургамлын бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	17	6	35.29
6	Технологи аюулгүй ажиллагааны зөвлөмж	15	8	53.33
7	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй	20	12	60.00



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

8	Хог хаягдлын менежмент	27	16	59.26
9	Ахуйн хог хаягдлын менежмент	7	6	85.71
10	Аюултай хог хаягдал (химийн бодис) менежмент	10	2	20.00
11	Эрүүл мэндийн халдвартай хог хаягдлын менежмент	7	1	14.29
12	Аюултай хог хаягдал (шатах тослох материал)-ын менежмент	7	4	57.14
13	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	15	12	80.00
Нийт		188	97	51.79
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (5 жил)				
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	8	5	62.50
2	Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	6	4	66.67
3	Хөрсний чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	8	5	62.50
4	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	3	2	66.67
5	Ургамлын бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	2	2	100.00
6	Нөхөн сэргээлт	4	3	75.00
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	10	5	50.00
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	8	3	37.50
9	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	12	12	100.00
10	Орчны хяналт шинжилгээ	11	11	100.00
Нийт		72	52	72.08

4.1. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Агаарын бохирдол” гэж хүрээлэн байгаа орчны агаарт шууд хаягдсан болон физик, химийн урвалын дүнд шинээр үүсэж бий болсон бохирдуулах бодисын агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхийг хэлнэ. Төслийн үйл ажиллагааны явцад газар шорооны ажил, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт, хүдэр тээвэрлэлт, хүдэр бутлалт зэрэгт их хэмжээний тоосжилт үүсэх магадлалтай байдаг. Агаар мандалд эргэлдэж байгаа янз бүрийн хэлбэртэй хатуу, жижиг хэсгүүдийг тоос гэнэ.

4.1.1. Төслийн талбай орчим болон ажлын байрны доторх агаараас NO₂, SO₂, PM₁₀, PM_{2.5} сорьц дээж авч, шинжилгээ хийх, түвшинг тодорхойлох.

Төслийн талбай орчмын агаарын чанарын хяналт шинжилгээг Монгол улсын Итгэмжлэгдсэн лаборатори болох Орхон аймгийн УЦУОШТөвийн БОШЛ-д 2023 оны 1 сарын 5-ны өдрийн ҮҮГ-23/018 тоот “Үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу MNS 17-2-5-12:2021 Байгаль орчин. Агаар дахь хүхэрлэг хийн агууламжийг тодорхойлох Тетрахлормеркурат натрийн арга, MNS 17-2-5-11:2021 Байгаль орчин. Агаар дахь азотын давхар ислийн агууламжийг тодорхойлох Гриссийн арга стандартуудын дагуу гүйцэтгүүлж



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

байна. Шинжилгээний үр дүнг Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартад харьцуулан үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулан ажиллаж байна.

Хүснэг-9. Агаарын чанарын шинжилгээний цэгүүд.

№	Сорьц авсан цэгийн нэр	Сорьцын байршил	Шинжлэх үзүүлэлтүүд мг/м ³	
№01	Катодын зэс боловсруулах үйлдвэрийн технологийн зам	х-0435572 у-5426885	SO ₂ , NO ₂	Нийт тоос/TSP/, дуу шуугиан дБ (А)
№02	Үйлдвэрийн орчим /SX, EW/	х-0436117 у-5426576	SO ₂ , NO ₂	Нийт тоос/TSP/, Нарийн ширхэглэгт тоос/PM2.5/, Том ширхэглэгт тоос /PM-10/, дуу шуугиан дБ (А)
№03	Нуруулдан уусгалтын талбай	х-0436269 у-5427040	SO ₂ , NO ₂	Нийт тоос/TSP/, дуу шуугиан дБ (А)
№04	Бутлуур орчим	х-0436269 у-5427040	SO ₂ , NO ₂	Нийт тоос/TSP/, Нарийн ширхэглэгт тоос/PM2.5/, Том ширхэглэгт тоос /PM-10/, дуу шуугиан дБ (А)
№05	Уурын зуухны яндан орчим	х-0436068 у-5426336	SO ₂ , NO ₂	Нийт тоос/TSP/, Нарийн ширхэглэгт тоос/PM2.5/, Том ширхэглэгт тоос /PM-10/, дуу шуугиан дБ (А)
№06	Түлшний нөөцийн сав орчимд	х-0436119, у-5426570	SO ₂ , NO ₂	Нийт тоос/TSP/, дуу шуугиан дБ (А)

9	SX үйлдвэрийн цөөрөм	1290	104° 07' 39.3"	48° 59' 20.8"	Агрохими, механик бүрэлдэхүүн, хүнд металл	Ханлаб ХХК, ШУА-ын Газарзүй-Геозкологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори
10	Нуруулдан уусгалтын талбай-1, CELL3 урд хэсэг	1291	104° 07' 36.6"	48° 59' 25.9"		
11	Нуруулдан уусгалтын талбай-1, CELL2 урд хэсэг	1293	104° 07' 26.2"	48° 59' 23.9"	Агрохими, механик бүрэлдэхүүн, хүнд металл	Ханлаб ХХК, ШУА-ын Газарзүй-Геозкологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори
12	Нуруулдан уусгалтын талбай-1, CELL1 баруун хэсэг	1299	104° 07' 14.6"	48° 59' 25.1"		
13	Ядуу уусмалын цөөрөм	1275	104° 07' 40.5"	48° 59' 15.8"	Агрохими, механик бүрэлдэхүүн, хүнд металл	Ханлаб ХХК, ШУА-ын Газарзүй-Геозкологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори
14	Хяналт (үйлдвэрийн бүсийн гадна)	1315	104° 07' 14.2"	48° 59' 09.5"		
Хөрсний нянгийн бохирдлын хяналт шинжилгээ						
1	Нүхэн жорлон (үйлдвэр, кэмп)	1292	104° 07' 15.2"	48° 59' 19.8 "	Нян	"Ханлаб" ХХК
2	Нүхэн жорлон (Персиммон ХХК)	1317	104° 08' 22.3"	48° 59' 33.8"	Нян	"Ханлаб" ХХК



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

3	Нүхэн жорлон (Шалган)	1287	104° 07' 31.5"	48° 59' 12.3"	Нян	"Ханлаб" ХХК
4	Энгийн хог хаягдал	1277	104° 07' 40.8"	48° 59' 12.6"	Нян	"Ханлаб" ХХК

4.3.5. Эвдэрсэн талбайн бүртгэл хөтөлж, ашиглалтын үед үүссэн жижиг талбай, эвдрэлийг тэгшилж хэлбэржүүлэх


Эвдэрсэн газар: Аливаа үйл ажиллагааны улмаас аж ахуйн анхдагч үнэ цэнээ алдаж, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эх үүсвэр болж хувирсан газар юм.

Тус эвдэрсэн газрууд нь “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий Э-2101000891 тоот 1068484м² газарт багтсан газар юм. Эвдэрсэн газрын бүртгэл нь эвдэрсэн газрын байршлыг газар дээр нь тодорхойлж, зураглал гарган хэмжээ чанар байдлыг тогтоох явдал юм. Цаашид төслийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын явцтай уялдуулан нөхөн сэргээх, тэгшлэх ажлуудыг шат дараатайгаар гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

Хүснэгт-20. Эвдэрсэн газрын бүртгэл


№	Эвдэрсэн газрын нэр	Талбай(V)m ³	Эзлэхүүн(S) m ²	Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Шимт хөрс	57680.0	10520.0	Стандартын дагуу хадгалах
2	Хөрсний эвдрэл-1	31020.0	21714.0	Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх
3	Хөрсний эвдрэл-2	21400.0	14980.0	
4	Хөрсний эвдрэл-3	8659.0	4329.0	
5	Хөрсний ухмал-1	6357.0	12807.0	
6	Хөрсний ухмал-2	9833.0	3933.0	
7	Хөрсний ухмал-3	16000.0	12384.0	Техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Зураг-30. Эвдэрсэн газрын план





**“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан
Зураг-31. Нөхөн сэргээлт хийхээс өмнөх болон дараах**



Үйлдвэрийн талбайд нэмэлт эвдрэл үүсгэхгүй байж үүсэн эвдрэлийг дахин ашиглахгүй тохиолдолд буцаан тэгшлэх зорилгоор үйлдвэрийн бүсэд “Хөрс хөндөх журам”-ыг батлан мөрдүүлж ажилладаг. “Хөрс хөндөх журам”-ын зорилго нь ашигт малтмал олборлох, боловсруулах явцаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг багасгах, бууруулах, орчны бохирдлоос урьдчилан сэргийлж хүн, амьтны аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, ашигт малтмал эрж хайх, олборлох ажлын явцад эвдэрсэн газрыг богино хугацаанд нөхөн сэргээх, үйлдвэрийн холбогдох мэргэжилтний хяналтгүйгээр газар, түүний хэвлийг эвдэхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахад чиглэдэг.

Энэ хүү журам нь Монгол улсын “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хууль Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 03 сарын 30-ны өдрийн А-138 тоот тушаалын хавсралт “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”, Байгаль орчны болон Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын хамтарсан 2000 оны 64/А/62 тоот тушаалын хоёрдугаар хавсралт, “Ашигт малтмал эрж хайх, олборлох явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж ургамалжуулах ерөнхий заавар”, “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах ерөнхий шаардлага” MNS 17.5.1.19-92, “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрснийг хуулах “Техникийн шаардлага” MNS 4917:2000, “Эвдэрсэн



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

газрын хажуу налуу" Техникийн шаардлага MNS 4920:2000, "Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс" Техникийн шаардлага MNS 4919:2000, "Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага" MNS 4918:2000, “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёоны тодорхойлолт” 5914:2008 гэх мэт баримт бичгүүд түүнтэй холбоотой дүрэм журмуудыг үйлдвэрийн бүсэд хэрэгжүүлэн мөрдөж ажиллах үндсэн баримт бичиг бөгөөд “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн нийт ажилтан, ажиллагсад гэрээт болон туслан гүйцэтгэгч компани, зочид төлөөлөгчид мөрдөн ажиллана.

Зураг-32. Хөрс хөндөх журам

АГУУЛГА	НЭР, АЛБАН ТУВААЛ	ОГНОО	ГАРЫН ҮСЭГ
Боловсруулсан	Байгаль орчны мэргэжлэтэн Ц.МЭНДЭБАЯР	2023.06.05	
Хянан	ХАБЭАБОХ-ийн менежер П.Батболд	2023.06.05	
Өөрчлөлт	Хойруутгар хийгээд		

“ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-НИЙ ХӨДӨЛМӨРНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЭЛТЭС

Хүсэлт гаргасан өгнөө:	Хүсэлтийн дугаар			
Хүсэлт гаргасан алба/Гэрээт компани				
Хүсэлт гаргасан ажиглалтын нэр	Утасны дугаар			
Албан тушаал				
Хөрс хөндөх ажлын байршил	Байршлын нэр	Координат	Байршлын нэр	Координат
	Үйлдвэрийн бүс	X: Y:		X: Y:
	Кемп	X: Y:		X: Y:
	Оффис	X: Y:		X: Y:
		X: Y:		X: Y:
		X: Y:		X: Y:
		X: Y:		X: Y:
		X: Y:		X: Y:
Байршлын талаарх нэмэлт мэдээлэл:				
<input type="checkbox"/> Газар хөндөх шалтгаан <input type="checkbox"/> Шингт хөрс хуураалт <input type="checkbox"/> Барилгын ажил <input type="checkbox"/> Нүх, суваг, шуудуу				
<input type="checkbox"/> Газар хөндөх шалтгаан <input type="checkbox"/> Олборлолт <input type="checkbox"/> Хаалт, хашаа <input type="checkbox"/> Далав/хаалт				
<input type="checkbox"/> Бусад бол нэмэлт тайлбар бичих <input type="checkbox"/> Технологийн зам <input type="checkbox"/> Хайрга олборлолт <input type="checkbox"/> Бусад				
<input type="checkbox"/> Ажлын танилцуулга <input type="checkbox"/> Байршлын зураг <input type="checkbox"/> Бусад				
Хавсралт материал	Өргөх талбайн хэмжээ/м²		Хөрс хуураалтын хэмжээ/м³	
	Шингт хөрс/м³		Хаагдал хөрс/м³	
Ажлын товч танилцуулга бичих				

4.3.6. Химийн бодис хөрсөнд асгарсан тохиолдолд хөрсийг солих, саармагжуулж хаях арга хэмжээг авах, саармагжуулах материалууд бэлэн байлгах, асгаралт саармагжуулах журам боловсруулж мөрдөх

“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн “Катодын зэс боловсруулах үйлдвэр” /цаашид үйлдвэр гэх/-н үйл ажиллагааны явцад болон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, хүдэр тээвэрлэлт болон бусад холбогдох үйл ажиллагааны үүсэж болзошгүй асгаралт (электролит уусмал, хүчил, шүлт, химийн бодис агуулсан органик уусмал, аюултай хог хаягдлын сав баглаа боодол, түлш, тос, масло, тосолгооны материалууд, ахуйн шингэн, хатуу хог хаягдал, барилгын хатуу хог хаягдал, цемент) зэргийн асгаралтын үед авах арга хэмжээг шуурхай зохион байгуулж байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахад энэхүү журмын зорилго оршино.

Үйлдвэрийн бүсэд үүсэж болзошгүй асгаралтуудыг дараах байдлаар саармагжуулахаар бэлтгэл бэлэн байдлын хангаж ажилладаг.

Хүснэгт-21. Асгаралт саармагжуулах

№	Асгаралтын нэр	Саармагжуулах	Саармагжуулах бодис	Бэлэн байдал,
---	----------------	---------------	---------------------	---------------



“Ээс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

		арга		нөөц
1	Электролит уусмал/хүчил, шүлт, химийн бодис, CuSO4)	Хими, механик	Сода-н уусмал, шохойн уусмал, шингээгч элс, арчих материал	1.0тн
2	Аюултай хог хаягдлын сав баглаа боодол	механик	Харьяалах нэгжид зөрчил аргах шаардлага хүргүүлнэ зөрчлийг арилгуулж ажиллана.	Аюултай хог хаягдлын агуулах
3	Түлш, тос, масло, тосолгооны материалууд	Хими, механик	Үүссэн асгаралтыг хусаж цэвэрлэн асгаралт саармагжуулах талбайд байршуулж саармагжуулна.	Аюултай хог хаягдлын агуулах 5.0тн
4	Ахуйн шингэн	хими	Хлорамины шохой, хлорын уусмалаар талбайг ариутгана.	200.0кг
5	Цемент	механик	Харьяалах нэгжид зөрчил аргах шаардлага хүргүүлнэ зөрчлийг арилгуулж ажиллана.	Хог хаягдлын нэгдсэн цэг

Зураг-33. Асгаралт саармагжуулах элс, шохой



Зураг-34. Асгаралт саармагжуулах, урьдчилан сэргийлэх журам



“Ээс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

“ЭЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-НИЙ ХОДОО ТӨВРИЙН АЮУЛ ГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ ХАХИЙН БАЙН АТЬ ОРЧНЫ ХЭТГЭС

Батлах:
“Ээс эрдэнийн хувь” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал **Б. Мөнхбаяр**

“ЭЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-НИЙ “АСТАРАЛТ БҮРТГЭХ, СААРМАГЖУУЛАХ” ЖУРАМ
ЭЭХ. ХАБЗАВО-01/008

АГУУЛГА	НЭР, АЛБАН ТУШААЛ	ОГНОО	ГАРЫН ҮСЭГ
Боловруулсан	БО-ны мэргэжлэгч Ц.Мэсхбаяр	2023.06.05	
Хянасан	ХАБЗАВОХ-ийн менежер П.Батболд	2023.06.05	
Өөрчилсөт	Хайрсуугаар хэлэлцэ		

Орлон аймэг
2023 он

“Ээс эрдэнийн хувь” ХХК-ийн
Гүйцэтгэх захирлын 20... оны... сарын...-ны өдрийн
... тоотын тушаалын Хөйрлүүсээр хяналтын

АСТАРАЛТ БҮРТГЭХ ХУУДАС

◆ Мэдээтэй болсноо: **№**

Астаралт болсон он сар: _____ Харьяалагдах хэлтэс/ Гэрээт компани: _____

Астарахтай талвар мэдээлсэн ажлынх өмөг үзэ:

Утас: _____ Албан туснаа: _____

Байрлал:	ХММЭ-н талбай		ШТС		Нуруулан уусгалтын талбай	
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Уйлдвор /SX/	Паркын талбай	Усны эх үүсвэр	Бусад	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	<input type="checkbox"/>	Лаборатори	Технологийн зан	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
	<input type="checkbox"/>					

Болордоом хорсны хэмжээ: _____ Астарахтай байршил бичгээр: _____
Байршилын талаарх нэмэлт тайлбар: _____

Астаралт болсон цаг: _____

Астаралт үүсгэсэн эх үүсвэрийн мэдээлэл

Тонот төлөөрөгчийн төрөл:	Тайлбар	Тонот төлөөрөгчийн №:

Астаралт үүсэх хүртэлх үйл явц ямар ажил тийлэгдэ болсон? _____

Астаралт үүссэн шалтгаан: Тайлбар

Шингэний хэл дүүргэсэн

Техник, тоног төхөөрөмжийн зориулалтын дагуу шингэнгүй

Санаасар болгоомжуулжээ

Буруу техник ашигласан

Сургалт хангалтгүй

Жайргич сэтгэсэн, дамауулах хөндлөй алдарсан

Бусад

◆ Бийлгээ орчны мэдээлэл болсноо: **№**

Астарах бүтээгдэхүүний төрөл:			
Шингэн	<input type="checkbox"/>	Хэмжээ (г, тн, м³)	Хатуу
Астарах бүтээгдэхүүн:	<input type="checkbox"/>		Астарах бүтээгдэхүүн
	<input type="checkbox"/>		

Хуудас 1/2

4.4. УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн талбайн ургамлан нөмрөгийн ашиглалт нь олон жилийн турш бэлчээрийн зориулалтаар ашиглаж ирсэн бөгөөд хадлан хадах зэргээр ашиглаж байсан мэдээ одоогоор бүртгэгдээгүй байна. Ургамлан нөмрөгийн бүрэлдэхүүний доройтол нь малын хөлийн талхагдал болон байгалийн хүчин зүйлийн зүй тогтол, авто замын трассын нөлөөнд орсон байдлаар ажиглагдаж байна.

4.4.1. Боломжит газруудад ногоон байгууламжийг зохих арга технологийн дагуу байгуулах.


Үйлдвэрийн үйл ажиллагаатай уялдан бүтээн байгуулалтын ажил давхар хийгдэж байгаа тул ногоон байгууламжийг маш зөв тооцоолох шаардлагатай байгаа юм. Иймд бид эхний жилүүдэд ногоон байгууламжийг үйлдвэрийн салхины хамгаалалтын зурвас байгуулах байдлаар хийж эхлээд байна.

2023 оны хавар намрын улиралд ногоон байгууламжийн нэмэгдүүлэх чиглэлээр нийт 900 ширхэг шар хуайс, 100 ширхэг нарс, хайлаас монос, бүйлс тарив. Ургалтын 90 хувьтай байна. MNS 6139:2010 Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага MNS 6141:2010 Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага MNS 6255 :2011 Сөөгийн суулгац. Ерөнхий шаардлага MNS 6256 :2011 Сөөгөнцрийн суулгац. Ерөнхий шаардлага MNS 6257 :2011 Улиасны суулгац. Ерөнхий шаардлага MNS 6258-2:2011 Мод, сөөгийн суулгац арчлах. Техникийн шаардлага ГОСТ 24909 : 1981 Чимэглэлийн навчит төрлийн модны суулгац . Техникийн шаардлага. ГОСТ 25769-83 Хотын ногоон байгууламжид зориулсан шилмүүст төрлийн модны



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан суулгац. Техникийн шаардлага. ГОСТ 28829-90 Хамгаалагдсан хөрстэй мод сөөгийн суулгац. Техникийн шаардлага зэрэг стандартуудыг хэрэгжүүлэн ажиллав.

Зураг-35. Үйлдвэрийн бүсийн ногоон байгууламж






“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

4.4.2. Ургамлан нөмрөгийн өсөлт, хөгжилт, өөрчлөлтөд тодорхой давтамжтайгаар мониторинг буюу судалгааг хийлгэх

Орхон аймаг нь Евроазийн хээр, Монголын хээрийн муж, Орхон- Сэлэнгийн дэд мужид багтана. Орхон аймагт нийт 17792 га талбайд ой модны тархац бий. Ойн бүслүүр зөвхөн уулын ар хажуугаар тархах бөгөөд сибир шинэс, улиас, улиангар голлож ургана. Ойн ургамалжилт алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн, ботуульт, бэсрэг уулсын хээр болно. Уулын хээр ургамалжилт алаг өвст, цахилдагт, улалжит тайгархаг шинэсэн ой ба түүнийг орлож ургасан хусан ой байна. Ойт хээрийн бус нь хар мод, улиас, бургас, улингар, зэрэг мод голлож, мөн модлог, бутлаг, ургамал бөөрөлзгөнө, буриагуул, тавилгана, нохой хошуу, хар урт, яргай зэрэг болно.

Зураг-36. Байгалийн бус бүслүүр ба экосистем



Судалгааны арга зүй: Ургамалжил, бэлчээрийн ургамлын ангилаа бүртгэл, түүний тархцыг тодорхойлох зорилгоор ургамлын бүлгэмдэл түүнийг бүрдүүлж буй ургамлын зүйлийн баялгийн жагсаалтыг гаргах зорилгоор бүлгэмдэл тус бүрд тухайн бүлгэмдлийг төлөөлөх талбайг сонгон талбайд ургамалжилзүйн бичиглэл хийсэн.

➤ **Зүйлийн баялаг:** Ургамалжлын зүйлийн баялгийг тодорхойлохдоо нийт талбайн хэмжээнд тархсан ургамлын баялгийг флорын баялаг тодорхойлох аргаар бүртгэж, зүйлийн латин, монгол нэрийг (Грубов, 1982) бүтээлд зааснаар нэрлэв;

➤ **Тусгаг бүрхэц:** Бүлгэмдэл тус бүрийн ургамлын арви-бүрхцийг тодорхойлохдоо Браун-Бланкегийн аргаар (Раменский, 1938) 1м2 хэмжээт торыг ашиглан бүлгэмдлийн хэмжээнд сонгож авсан талбай бүрд 3 давталттайгаар арви- бүрхцийг

➤ **Ургамлын өсөлт:** Ургамлын өсөлтийг тодорхойлохдоо зүйл тус бүрийн ургамлын өндрийг мм-ийн нарийвчлалтай шугамаар хэмжиж тодорхойлсон;



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

➤ **Зураглалын арга зүй:** Судалгааны талбайгаас авсан мэдээлэл, агаар сансрын зургийг үндэслэн Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд тархсан ургамлан нөмрөгийн тархалтын 1:50000 масштабтай сэдэвчилсэн зураг зохиосон;


Судалгааны үр дүн: Ургамалжилтын төрөл тархцыг тодорхойлохдоо Монгол орны хэмжээнд 1:1000000 масштабтаар харуулсан зургийг ашиглав. Энэхүү зураг нь Монгол-Оросын судлаачдын агаар сансрын зураг ашиглан хийсэн сэдэвчилсэн цуврал зургийн нэг бөгөөд Байгаль орчны мэдээллийн сангаас авсан болно. Монгол орны хэмжээнд нийт 182 төрлийн ургамалжилтыг харуулсан байна. Төслийн талбайн район буюу Орхон аймгийн Баян-Өндөр сумын хэмжээнд ялгаатай 8 хэв шинж тархсан байна.

Үүнд:

1. Биелэг- алаг өвс ба биелэг-улалж- алаг өвст
2. Бургас оролцсон улалж-гол өвс-улаан толгойт ба улаан толгой-алаг өвст
3. Согоовтор, царгас, мөлхөө хиаг хошоон, төмөрдээ зонхилсон үетэн-буурцагтаналаг өвст
4. Тариалан
5. Тэжээлийн ач холбогдолгүй уулын тайга
6. Хялгана- зүр өвс- алаг өвст (20%) ба ботууль-алаг өвстэй (10%) шинэсэн болон шинэс- хусан ойн алаг өвс- үетэнт бүлгэмдэл
7. Чулуурхаг алаг өвс-ботуульт (20%) ба шинэс-хусан ойн өвслөг (10%) ерхөг улалж-алаг өвст бүлгэмдэл
8. Чулуурхаг алаг-өвс- ботуультай (20%) хялгана- ерхөг-алаг өвст бүлгэмдэл Биелэг-алаг өвс ба биелэг-улалж-алаг өвст бүлгэмдэл

Судалгаа явуулсан нутаг буюу төслийн талбай орчим биелэг-улалж- алаг өвст бүлгэмдэл тархана. Төслийн талбайн ургамлан нөмрөг, байгалийн төрх бүрэн өөрчлөгдөж, хог ургамал бүхий бүлгэмдлээр солигдсон. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг авч үзвэл *Chenopodium aristatum* L, *Chenopodium acuminatum* Willd, *Chenopodium album* L, *Chenopodium glaucum* L, *Atriplex sibirica* L, *Axyris prostrata* L, *Axyris amaranthoides* L, *Saussurea amara* DC, *Corispermum mongolicum* Pjin, *Corispermum declinatum* Steph, *Artemisia frigida* Willd, *Artemisia macrocephala* Jacquem, *Potentilla anserina* L, *Potentilla multifida* L, *Urtica cannabina* L. зэрэг хог ургамал давамгайлан ургасан байна. 1 м² талбайд дунджаар 1-2 зүйл ургамал тохиолдож, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр ургамлан нөмрөг талхлагдсан байна.

Манай үйлдвэрийн бүсийн талбайн зарим хэсэгт ургамлан нөмрөг, байгалийн төрх бүрэн өөрчлөгдөж, хог ургамал бүхий бүлгэмдлээр солигдсон байгаа тул хог ургамлыг түүж устгах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Мөн үйлдвэрийн талбай хатуу хучилттай биш сул чөлөөтэй талбайд модлог ургамал, мод тарих, ногоон байгууламжийг жил бүр нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ын дагуу иргэн, аж ахуй нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх шаардлагыг биелүүлэх зорилтыг дэвшүүлээд байна.



4.4.3. Төслийн талбайд тариалалт хийх зориулалт бүхий мод үржүүлгийн газар байгуулах

Мод үржүүлгийн газар нь мод сөөгийн тарьц, суулгацыг ургуулах, үржүүлэх зориулалт бүхий ойн аж ахуйн нэг хэсэг билээ. Тарьц суулгацыг үрээр болон ургал эрхтнээр үржүүлэх мөн далд болон ил үндэсний системтэй суулгац үржлийн материал зэргийг бэлтгэн ойжуулалтын ажилд нийлүүлнэ. МҮГ-ын загвар боловсруулах гол зарчим бол өндөр чанарын тарьц суулгац үйлдвэрлэх явдал юм. Тарьц суулгац үйлдвэрлэлийн амжилтыг тодорхойлох хоёр үндсэн элемент нь хүрээлэн буй орчны хүчин зүйлүүд болон МҮГ-д тарьц суулгац үйлдвэрлэх арга техник юм МҮГ-ыг байгуулах тохиромжтой талбайг сонгохдоо тал бүрээс нь шинжин судалж тогтоох шаардлагатай. Эс тэгвэл явцын дунд сөрөг үр дагаврууд илэрч түүнийг засахад төвөгтэй болдог. МҮГ-ыг байгуулахдаа талбайг сонгохдоо санал болгож буй талбайн байршил, хөрс, цаг уурын хүчин зүйл, топографи, эдийн засгийн хүчин зүйл, усан хангамж зэрэг хэд хэдэн чухал хүчин зүйлүүдийг харгалзан үзэх хэрэгтэй. МҮГ-ыг байгуулахад шаардлагатай журам, стандарт:

- Мод үржүүлгийн газрын талбай сонгох арга. Техникийн шаардлага MNS 6138:2010
- Мод сөөгийн үр тарих, ерөнхий шаардлага MNS6253-2:2011
- Мод үржүүлгийн газар бордоо хэрэглэх MNS 6252:2011
- Мод үржүүлгийн газрын хөрс боловсруулах MNS 2418:2011
- Мод, сөөгийн тарьц. Техникийн шаардлага MNS 6140:2010



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан


Баян-Өндөр сумаас мод үржүүлгийн газрын зориулалтаар олгосон 1.5га талбайд салхины хамгаалалтын зурвасаар хайлаас, бүйлс, шар хуайс модны тарьц суулгацыг шуугаар болон нүхэлсэн хэлбэрээр 3 эгнээ тариалж хашаажуулах ажил хийгдэв.

Байршлын координат:	х-433674.00	у-5425338.00
	х-433661.00	у-5425436.00
	х-433811.00	у-5425429.00

Зураг-38. Мод үржүүлгийн газрын бэлтгэл ажил




Зураг-39. Мод үржүүлгийн газрын талбай



Зураг-40. Мод үржүүлгийн газрын талбайн бэлтгэл ажил



Зураг-41. Мод үржүүлгийн газрын хашаа, хамгаалалт



Зураг-42. Мод үржүүлгийн газрын салхины хамгаалалтын зурвас





Зураг-43. Мод үржүүлгийн газрын үрийн нөөц



4.5. АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.5.1. Төсөл хэрэгжих сум орон нутгийн амьтны аймгийн төрөл зүйл, тархалт, тоо толгойн талаарх мониторинг судалгааг хийлгэх

Орхон аймгийн нутгаар зэрлэг гахай, халиун буга, бор гөрөөс, саарал чоно, хярс, үнэг, өмхий хүрэн, тарвага, суулт зурам, хээрийн шувуу, ойн шувуу, идлэг шонхор, тас, тоншуул, олон төрлийн усны болон намгийн шувуу, монгол бах зэрэг амьтад тархсан байна. Ойн сан болон бэлчээрийн талбайд хөхтөн амьтны 41 зүйл, хоёр нутагтны 2 зүйл, мөлхөгчдийн 4 зүйл, шувууны 124 зүйл, загасны 5 зүйл, шавжийн 215 зүйл тархан амьдарч байна. Орхон аймгийн Баян-Өндөр суманд байрлах төслийн талбай болон түүний орчим нь амьтны аймгийн хувьд Монгол орны




“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

амьтны аймгийн газарзүйн хуваарилалтаар уулархаг азийн дэд их муж, Монгол Төвдийн муж, хээрийн дэд мужийн Хангайн тойрогт хамрагдана. Хотжилт суурьшил үүссэнээс амьтны аймаг багагүй нөлөөлж зарим синантроп зүйлийн амьтад үзэгдэх болсон. Тухайлбал, хон хэрээ, улаан хошуут, сохор элээ, хөхвөр тагтаа г.м. Амьтны аймгийн хөхтөн, шувуу, шавж гэсэн анги бүлгийн төлөөлөгчид тархана. Тухайн бүс нутаг нь хот сууринтай ойр учир амьтны аймгийн томоохон төлөөлөгч байхгүй, харин шувуу, сээр нуруугүйтэн дунд зэрэг тархалттай. Хөхтөн- Тус нутагт хээрийн хөхтний бүлгэмдлийн Огдойн бүлэгт хамаарах, ургамлын ногоон хэсгээр хооллодог, жилийн турш идэвхтэй амьдрагч , дунд зэрэг малтах үйл ажиллагаатай жижиг хөхтнүүд тохиолдоно. Экологийн тодорхойлолтын хувьд эдгээр нь байгалийн нүх хонгил, өөрийнхөө нүхэнд түр болон удаан хугацааны туршид амьдарч хөрсөн дээрээс ургамлын шим багатай, шимтэй хэсэг, мөн сээр нуруугүйтнээр хооллодог онцлогтой. Шувуу- Суурин ба өндөглөж зусдаг, өндөглөхүй зусдаг, ургамал, сээр нуруутан болон хүүр сэгээр хооллогч шувууд тархана. Уулын хээрийн бүлгэмдэлд багтах: Шоорон алаг болжмор- *Eremophila glpestris*, хон хэрээ-*Corvus corax*, Оронгийн бор шувуу-*Paster domesticus* элбэг, Сохор элээ-*Milvus migrans*, хайргын хөгчүү-*Actilis hypoleucos*, Үхэр цахлай-*Larus argentatus*, Хөхтөр тагтаа-*Columba libia* хэвийн, хадны тагтаа-*Columba rupestris*, Хотны бүгээхэй-*athene postua*, Монгол хараацай-*Hirundo daurica*, хээрийн шиншүүхэй-*Anthus richardi* цөөн тохиолдоно.

4.5.2. Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамд шувуу үргээгч суурилуулж шувуу хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх

“Катодын зэсийн үйлдвэр”-ийн талбайд цахилгааны үндсэн 5 хэрэглэгч байх ба үүнд хүдэр бэлтгэх хэсэг, шимт уусмал-хандлалтын хэсэг, электролизийн хэсэг, уурын зуухны хэсэг болон бусад дэд бүтцийн байгууламжуудын хэсэг багтана. Ерөнхий бууруулах дэд станцын ерөнхий тэжээлийн трансформаторыг 4000кВА чадалтай 10/0.4 кВ-ын 2 фазын трансформатор, харин бусад дэд бүтцийн барилга байгууламжид 630 кВА чадалтай 10/0.4 кВ трансформаторыг сонгосон байна. Төслийн цахилгаан хангамжийн төлөвлөлтөд нийт 10.6 км урттай 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татахаар төлөвлөн цахилгааны шугам татах ажил хийгдэж дууссан.

Зураг-44. Үйлдвэрийн цахилгаан хангамжийн төлөвлөлт





“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

4.5.3. Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамын шувуу цахилгаанд цохиулж буй эсэх хяналт судалгаа хийх

Мэргэжлийн байгууллагын хийсэн “Шонхор” шувууны судалгаагаар амьдрах орчны доройтол, өөрчлөлт, идэш тэжээлийн хомсдол, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрчимжилт, хууль бус болон зохицуулалтгүй улс дамжсан наймаа хэт ихэссэн, уурхайлалт болон хууль бус алт олборлогчдын нөлөөллөөр хөрсний эвдрэл эхээр үүссэн, өндөр хүчдэлийн шугамыг шувуу үргэгчгүй хийснээр үй олноороо цахилгаанд зохиулж үхэх зэргээс үүдэн идлэг шонхрын тоо толгой тархац нутаг бүх хэсэгтээ огцом буурч зарим орон нутагт устаж үгүй болоод байна хэмээн дурдсан байдаг.

Зураг-45. Өндөр хүчдэлийн цахилгаан шугамын үзлэг



5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5.1. Төслийн талбайд тохижуулалтын журмаар мод тариалах, ногоон байгууламж бий болгох, тариалалт хийх талбайн хөрсийг бордох сайжруулах, мод усалгаа, арчилгааг тогтмол гүйцэтгэх.

Газрын тухай хуулийн 56-р зүйлийн 6 дугаар заалтад “Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана” гэж заасны дагуу нийт талбайн 10 хувьд ногоон байгууламж байгуулах үүрэг хүлээнэ.

Зураг-46. Үйлдвэрийн бүсэд 2023 онд хийгдсэн ногоон байгууламж



Зураг-47. Үйлдвэрийн бүсэд 2023 онд хийгдсэн ногоон байгууламжийн талбай





6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дүйцүүлэн хамгаалах гэдэг нь төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ. Манай компани нь Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 сарын 4-ний өдрийн 58-р зарлиг, Засгийн газрын 2021 оны 11 сарын 17-ний өдрийн 350 дугаар тогтоолын хавсралтын 33 дугаар зүйл “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд мод тарих, ургуулах, арчлах үйл ажиллагааг тусган хэрэгжүүлэх” гэж заасны дагуу “Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжин оролцох нийгмийн хариуцлагын гэрээ”-ний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

6.1. “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд хавар, намрын бүх нийтээрээ мод тарих өдрүүдээр 2022 онд тарьсан ногоон зурвасаа үргэлжлүүлж 1000 –с дээш навчит болон шилмүүст моднуудыг тарьж ургуулж хамгаалах

Манай компанийн “Байгаль орчны бодлого” нь хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулан хамгаалах, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, ард иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах эрхийг хангахад үндэслэсэн ба дараах 3 чиглэлд хэрэгжиж байна.

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- Байгаль орчны хууль эрхзүйн хүрээнд мөрдөгдөх хууль тогтоомжийн сахин мөрдөлтийг биелүүлэх
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймгийн Засаг даргатай байгуулсан 2022/04 тоот “Тэрбум мод хөдөлгөөнийг дэмжин оролцох нийгмийн хариуцлагын гэрээ”-ний хэрэгжилтийг хангах

Мод тарилтын ажлыг гүйцэтгэхдээ “Мод тарих гарын авлага” Улаанбаатар хот 2017он, “Ойжуулалт” Улаанбаатар хот 2022он. Жигжидийн Бат-Эрдэнэ, Чулуунгомбын Базарсад,



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

MNS5995:2009 Мод сөөгийн үр тариалалтын чанар, Техникийн ерөнхий шаардлага, MNS6140:2010 Мод сөөгийн тарьц, Техникийн ерөнхий шаардлага, Ч.Дугаржав (Sc.D) “Ойжуулагч цэцэрлэгчдийн лавлах толь”, Цөлжилтийг бууруулах газрын тогтвортой менежмент МОН08/301/ төсөл “Улиас тарьж ургуулах гарыг авлага”, “Харгана тарьж ургуулах гарын авлага”, Д.Энхсайхан (Sc.D) “Монгол орны мод сөөг” Улаанбаатар 2016он, “Монгол орны ойд зонхилох хөнөөлт эрвээхэйг таних, тэмцэх арга ажиллагаа”, “Ойн мэргэжлийн ажилтны гарын авлага” зэрэг бичиг баримтуудыг удирдлага болгов.

Хүснэгт-22. 2023 онд тарьж ургуулсан тарьц суулгацын тоо ширхэг

№	Тарьц суулгацын нэр	Хэмжих нэгж	Тоо/ширхэг	
			5-6 сар	10-11сар
1	Улиас	ш	500.0	0.0
2	Хайлаас	ш	100.0	785.0
3	Шар хуайс	ш	160.0	1538.0
4	Монос	ш	100.0	32.0
5	Бүйлс	ш	150.0	145.0
6	Нарс	ш	100.0	0.0
Нийт			1110.0	2462.0
			3572.0	

➤ **Технологийн замын дагуу салхины хамгаалалтын зурвас байгуулах (2023 оны хавар)**

Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутагт үйл ажиллагаа явуулж буй “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн талбайн хил залгаа технологийн зам дагууд 500 ширхэг улиас модыг замын 2 талаар тус бүр 2 эгнээ тариалав.

Мөн үйлдвэрийн бүсийн ногоон байгууламжид хайлаас -100ш, шар хуайс-160ш, монос-100ш, бүйлс-150ш, нарс-100ш буюу нийт 1140 ш модыг үйлдвэрийн бүсийн салхины хамгаалалтын зурвас, тохижуулалт, технологийн замын салхины хамгаалалтын зурвасаар шинээр тарьж хашаажуулав. Нийт тарьсан модны ургалт 90%-тай байна.

Байршлын координат:	х-434717.00	у-5426323.00
	х-434834.00	у-5426435.00
	х-435660.00	у-5426666.00
	х-435632.00	у-5426657.00
	х-435909.74	у-5426510.85
	х-435689.84	у-5426633.72

2022он болон 2023 оны хавар тарьсан нийт модонд 2500.0м бэлчээрийн торон хашаа, 1000.0м өргөст торон хашаа хийж бүрэн хашаажуулсан ба 2023 оны намрын тарилтаар нөхөн тарилтыг хийж гүйцэтгэв.

Зураг-48. Технологийн замын салхины хамгаалалтын зурвас байгуулсан талбай



Зураг-49. Технологийн замын салхины хамгаалалтын зурвас, хамгаалалтын хашиа (2023 оны хавар) “Тэрбум” мод хөтөлбөр





“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



➤ **Технологийн замын салхины хамгаалалтын зурвас (2023 оны намар)**


Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутагт мэргэжлийн байгууллагаас заасан байршил буюу “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн технологийн замын дагууд 2022 он болон 2023 оны хаврын мод тарилт хийсэн талбайг үргэлжлүүлэн 500 ширхэг хайлаас модыг замын урд талаар тус бүр 2 эгнээ тариалж хашаажуулах ажил хийгдэж байна.

Байршлын координат: х-434032.00

у-5426105.00

Зураг-50. 2023 оны намрын мод тарилт, хашаажуулалт







6.2. “COPPER FESTIVAL” эвент арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн, хамтран зохион байгуулах

Монгол Улсын Засгийн газрын газраас 2023- 2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн онцлогийг илэрхийлсэн эвент арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулах зорилгоор Орхон аймаг, Эрдэнэт хот маань дэлхийн жишигт хүрсэн уул уурхайн салбараа сурталчлах “Зэс фестиваль” эвент арга хэмжээг 9 сарын 22, 23-ны өдрүүдэд зохион байгуулсан юм.

Уг арга хэмжээнд дараах арга хэмжээнд хамтран оролцов. Үүнд:

- Зэс фестиваль эвент арга хэмжээний баярын парад /нийт 50 ажилтан жагсаалд оролцов./
- Нээлтийн арга хэмжээн /Үйлдвэр технологийн газрын дарга Ц.Ариунболд оролцов./
- Ард иргэд үйлдвэртэй танилцах аялал /45 суудал бүхий автобусаар ард иргэдийг үйлдвэрт авч ирэн үйлдвэрийн бүтээн байгуулалттай танилцуулав./
- 9 сарын 22,23-ны өдөр талбайн Амарын талбайд үйлдвэрийн танилцуулга өдөрлөгийг зохион байгуулав.

Зураг-52. Зэс фестиваль






“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



September 22, 2023 12:13



September 22, 2023 12:55



7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол улсын ашигт малтмалын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1. “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна” гэж заасны дагуу төлөвлөн хэрэгжүүлнэ.

7.1. Төслийн талбайн орчимд зуны улиралд нутаглаж буй малчин өрхүүдэд малаа хариулгатай байлгаж, төслийн талбайн нөлөөллийн бүсэд бэлчээрлүүлэхгүй байх талаар мэдэгдэл хүргэх, бүлгийн уулзалт хийх

Манай үйлдвэрийн бүсийн орчимд өвчлөл эзэмшлийн газартай ард иргэд нутагладаггүй боловч зуны улиралд голын бэлчрээр айл өрхүүд мөн ихээр зусландаа гардаг. Манай компанийн зүгээр эдгээр айл өрхүүдэд бүлгийн уулзалт зохион байгуулан малаа хариулгатай байлгах, үйлдвэрийн талбай болон мод тарьсан талбай, модны хашаа сүйтгэхгүй байх анхааруулгыг байнга хүргүүлэн ажиллав.


Зураг-53. Малчдад зөвлөгөө өгөх, бүлгийн уулзалт

МАЛЧДАД ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛСЭН БҮРТГЭЛ					
д/д	Овог нэр	Байршил	Харьяах аймаг	Хүлээн авсан	Хүлээлгэн өгсөн
1	Ш.Чулуун-Эрэн	Увсгай талбай	Булган-Архангай	Чулуун-Эрэн	
2	Х.Баянсайхан	—	Булган-Архангай	Баянсайхан	
3	Н.Хишигсайхан	—	Орхон аймаг	Ашиг очирал	94253696
4	Ф.Дэлгэрсүхт	—	—	Дамбал	99353285
5	О.Орхонбаяр	—	Архангай	Орхонбаяр	94318161
6	Н.Орхонбаяр	—	Харьяах талбай	Орхонбаяр	94363978
7	В.Сүхбаатар	—	Төв-Ховдговь сумуудын талбай	Сүхбаатар	94363978
8	С.Мөнхсайхан	—	Дундговь	Мөнхсайхан	99960855
9	М.Ариунтөв	—	Увсгай талбай	М.Ариунтөв	94361434
10	С.Ариунтөв	—	Архангай	Т.Ариунтөв	99987154
11	Ц.Батбаяр	—	Увсгай талбай	Батбаяр	94363978





“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

 **ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ ХХК-ИЙН**
КАТОДЫН ЗЭС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР
МЭ

МАЛЧДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

2023.06.14 Орхон аймаг

Манай компани нь Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэрт нуруудан уугах технологийг “Катодын зэс боловсруулах үйлдвэр” үйл ажиллагаа явуулж байгаа билээ. Тус компани нь Орхон аймгийн Засаг даргын А/358 тоот шийдвэрийг үндэслэн Сархна уулын зүүн нэгэрт үйлдвэрлэлийн зориулалттай талбайг 15 жилийн хугацаатай эзэмшигчээр зөвшөөрөл авсан болно. Манай үйлдвэрийн технологийн замаар 24 цагийн турш хүнд машин механизм хүдэр тээвэрлэх, зам арчилгаа, услагаа хийх, ажигчдын автобус, бараа материал тээвэрлэх зэрэг авто машин байнга явдаг тул малчид та бүхэн Таван Эрдэнэ болох мал сүргээ үйлдвэрийн бүс болон хүнд машин механизм зориох технологийн замаар явуулахгүй байх, мал сүргээ хараа хяналттай хариуцгатай байлгана уу. Малчид та бүхэнд Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн 26 дугаар зүйлийн 26.5, 26.6-г үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд

- Малыг зам хөндлөн буюу гүүрээр тууж гаргахдаа 1.22 тэмдгээр анхаруулсан замын хэсгийг сонгох бөгөөд тийм хэсэг байхгүй бол замын дагуу хоёр тийш сайн харагдах, хайс, хашилтгүй хэсгээр, ойртон ирж яваа тээврийн хэрэгсэлгүй үед гаргана. Ингэхдээ аль болох түргэн, богиноор нь гаргах бөгөөд гүйцэд гаргаж амжаагүй байхад ойртон ирсэн тээврийн хэрэгсэлийн жооооч зам тавьж өгнө.
- Харанхуй үед замын гэрэлтүүлэггүй хэсэгт болон үзэгдэлт хангалтгүй нөхцөлд малыг замын дагуу тууж явахыг хориглоно. Харин зам хөндлөн тууж гаргах зайлшгүй тохиолдолд замын дагуу хоёр тийш тээврийн хэрэгсэл ирэх эгт гэрээ (диглүү) буюу гэрэл ойгуур барьсан хүн хашиж гаргана.
- Адуу, үхэр, хонь, ямаа, гэмээ зэрэг бэлчээрийн малыг үйлдвэрийн бүс болон технологийн замын ойролцоо бэлчээрлүүлэхгүй байх.
- Бэлчээрийн малыг харуулгатай байлгах.
- Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарваж байгаа мод, мод үржүүлгийн газрын ойролцоо малаа бэлчээхгүй байх.
- Шөнийн цагаар идэвхилдэг адуу, үхэр зэрэг бод малын хүзүүнд цаируулагч бүхий тууз зүүх.
- Үйлдвэрийн бүсэд машин механизмын хөдөлгөөн их байдаг тул малчид та бүхэн мотоцикл, авто машинтай явах үедээ өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж хурдаа тохируулж Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийг баримтлах замын тэмдэг тэмдэглэгээний дагуу хөдөлгөөнд оролцоно уу.



8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн 40¹ дүгээр зүйл. “Соёлын өвийг хамгаалах” 40¹.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 40², 46 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ. 40¹.2.Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. 40² дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг 40².1. “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь соёлын өвийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ, 40².1.2.Ашигт малтмал эрэх, хайх явцад олж илрүүлсэн соёлын өвийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хуульд заасны дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх ба тухайн өвийг холбогдох байгууллагад хадгалуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ” хэмээн заасан байдаг. “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн дагуу судалгаа, шинжилгээ, малталтын дүн болон палеонтологи, археологийн олдворыг сумын захиргаанд тайлагнах юм. Түүх, шинжлэх ухаан, соёлын үнэт зүйл болох газар, хөрс нь улсын хамгаалалтад байх бөгөөд олдвор нь улсын өмч болдог. Археологи ба палеонтологийн үнэт дурсгалт зүйлс нь аль болох байгалийнхаа байсан газарт нөөцлөгдөн хадгалагдах зарчимтай гэж хуульд заасан байдаг.

8.1. Үйлдвэрийн талбайд археологийн олдвор илэрсэн тохиолдолд хуулийн дагуу БОХУБ-д мэдээлж ажиллана.

Археологи: гэдэг нь эртний Грекийн ("archaiologia") (хуучин түүхийн өгүүлэл) гэсэн үгнээс гаралтай бөгөөд "archaios" буюу хуучин, эртний; "logos" буюу судлал, шинжлэл гэсэн үгийн нийлмэл бөгөөд үгчилбэл "хуучны судлал, эрт үеийг судлах ухаан" гэсэн утгатай үг юм. Энэхүү



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

нэр томьёог НТӨ 424-347 оны хооронд амьдарч байсан эртний Грекийн гүн ухаантан Платон анх өөрийн зохиолдоо тэмдэглэсэн бөгөөд эллинчүүд "археологи" хэмээх нэрийн дор баатарлаг хүмүүсийн угсаа залгамж, нүүдэллэн одогсдын тухай болон эртний хотын үүслийн тухай зэрэг эрт үед болж өнгөрсөн үйл явдлын тухай хүүрнэл болон эрэл хайгуул бүхнийг хамруулан "эртний хүмүүсийн амьдралын арга замыг судлах ухаан" гэж ойлгож болох юм. Үйлдвэрийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын явцад археологийн дурсгал илрээгүй болно.

8.2. Үйлдвэрийн талбайд палеонтологийн олдвор илэрсэн тохиолдолд хуулийн дагуу БОХУБ-д мэдээлж ажиллана.

Палеонтологи: (Грек гаралтай: *paleo*, "эртний"; *ontos*, "орших"; *logos*, "мэдлэг") нь эртний амьтан, ургамлын үлдэгдлийн судалгаан дээр тулгуурлан, дэлхий дээр оршин байсан эртний амьдрал, түүний төрлүүдийг тодорхойлдог Биологи ба Геологийн шинжлэх ухааны уулзвар дээр оршдог салбар шинжлэх ухаан юм. Палеонтологийн шинжлэх ухаан нь амьтдын эрмэл үлдэгдлийг олж тодорхойлсноор өнөө оршин буй байгалийн түүхийн далд хэсгийг нээн илрүүлж, улмаар эволюцын онолыг улам баталгаажуулж байдаг юм. Үйлдвэрийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын явцад палеонтологийн дурсгал илрээгүй болно.

9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Осол” гэж тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, аваар осол, хүний алдаатай үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх системийн хэвийн бус ажиллагааг хэлэх бөгөөд төслийн үйл ажиллагааны хүрээнд ирээдүйд үүсэж болзошгүй осол эрсдэлийг урьдчилсан таамаглан тодорхойлж байгаа болно.

“Байгалийн аюул” гэж хохирол, сүйрлийг өөртөө агуулж байж болзошгүй, биосферт явагддаг байгалийн үзэгдэл эсвэл үйл явцыг хэлэх бөгөөд төслийн үйл ажиллагааны хүрээнд ирээдүйд үүсч болзошгүй осол, байгалийн гамшгийг урьдчилан таамаглан тодорхойлж байгаа болно. Төслийн үйл ажиллагааны явцад хүний үйл ажиллагаа, техник технологи, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл болон байгалийн гамшиг, газар хөдлөл, үер, аянга цахилгаан хүчтэй шороон болон цасан шуурга зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр химийн бодисын осол эрсдэлээр үүсэж болзошгүй юм.

9.1. Химийн бодисын тусгай зөвшөөрөл, химийн бодисын орлого зарлагын бүртгэл хөтлөх, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.14-т заасан тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах, устгах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно, мөн хуулийн 13 дугаар зүйл болон 13 дугаар зүйлийн 13.7. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэл хөтөлж, тайлан мэдээг сум, дүүргийн Засаг даргад жил бүрийн 11 дүгээр



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

сарын 15-ны дотор, төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 1 дүгээр сард багтаан хүргүүлнэ гэж заасны дагуу дараах үйл ажиллагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Монгол улсын Мэргэжлийн хяналтын Улсын Ахлах байцаагчийн 2022 оны 08 сарын 12-ны өдрийн 14-04-004/132 “Баталгаажуулах үйл ажиллагаа хийсэн тухай” дүгнэлт,
- БОАЖЯ-ны 2022 оны 2 сарын 05-ны өдрийн 0002082 тоот “Химийн хорт бодис импортлох ашиглах зөвшөөрөл”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэв.
- Орхон аймгийн Баян-Өндөр суманд байрлах “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн Катодын зэс боловсруулах үйлдвэрт ашигласан химийн бодисын зарцуулалтын тайлан

Зураг-54. Химийн бодисын ашиглалтын тусгай зөвшөөрөл, тайлан

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

61029 Орхон аймгийн Баян-Өндөр сум, Зэс тусгай Залууруулах газар, Уулс/Фабрик 7030000, Шалны нэрлэлт: 9.0891000000000000

Баталгаажуулах үйл ажиллагаа хийсэн тухай

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛГАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ, ХЭЛ ДЭМЖҮҮЛЭХ ТЭГЭЭРЭГ, ҮЙДЭРГЭЛЭХ, АШИГЛАХ, ХУДАГДААХ АЖ АУЮУН ҮНЭ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ **ЗӨВШӨӨРӨЛ**

Огноо: 2022-02-15 Дугаар: 0002082 Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: Зэс эрдэнийн хувь ХХК
Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9011770093
Регистрийн дугаар: 5380082
Хаяг: Улаанбаатар, Баянтөл, 2-р хороо, МҮОНТ Ордон, 311 тоот

Утас: 99115878, 99104029

Дараах хэмийн хурчид, аюултай бодис: Импортлох, ашиглах 2022.02.15-2023.12.31

N	Материал	Салбар	Төлөө	Огноо үндэстэн	Ашиглах	Хэмжээ
1	Хүхрийн хүчил	Sulfuric Acid	H2SO4	7004-94-9		25000 тн
2	Lix 984 N	Lix 984 N	Хольц			180 тн
3	Кобальтын сульфат	Cobalt sulfate	CoSO4*7H2O	10025-24-1		10 тн
4	Гуарфлос	Guarflor-66	C2H2ClNNaO5S	127-65-1		8 тн

Улаан хэлээр илэрүүлэх бичиг: Замын-Ууд, Агтайбулаг, Сүрбатар

Зөвшөөрөл өгсөн: Байгаль орчин, агаар мууруулах, усны төрийн нэрийн бичгийн дарга Ц.БАТТУГАА

Химийн хорт бодис импортлох, ашиглах зөвшөөрөл олгох зориулалт хэрэглэх зориулалт Ц.БАТЖАРГАЛ

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛГАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ, ХЭЛ ДЭМЖҮҮЛЭХ ТЭГЭЭРЭГ, ҮЙДЭРГЭЛЭХ, АШИГЛАХ, ХУДАГДААХ АЖ АУЮУН ҮНЭ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ **ЗӨВШӨӨРӨЛ**

Огноо: 2023-02-10 Дугаар: 0002083 Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ ХХК
Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9011770093
Регистрийн дугаар: 5380082
Хаяг: Улаанбаатар, Баянтөл, 2-р хороо, МҮОНТ Ордон, 311 тоот

Утас: 99115878, 99104029

Дараах хэмийн хурчид, аюултай бодис: Ашиглах 2023.02.10-2027.12.31

Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох зориулалт

N	Материал	Салбар	Төлөө	Огноо үндэстэн	Ашиглах	Хэмжээ
1	Зэсийн хурчид					
2	Зэсийн хурчид					
3	Зэсийн хурчид					
4	Зэсийн хурчид					
5	Зэсийн хурчид					
6	Зэсийн хурчид					
7	Зэсийн хурчид					
8	Зэсийн хурчид					

Улаан хэлээр илэрүүлэх бичиг: Байгаль орчин, агаар мууруулах, усны төрийн нэрийн бичгийн дарга Ц.БАТТУГАА

Зөвшөөрөл өгсөн: Байгаль орчин, агаар мууруулах, усны төрийн нэрийн бичгийн дарга Ц.БАТЖАРГАЛ

“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн Үйлдвэр технологийн газрын дарга **Ц.Ариунболд**

Орхон аймгийн Баян-Өндөр суманд байрлах “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2022 оны 8 сарын 1-ээс 12 сарын 27-ыг дуусгах хугацаанд ашигласан нийт химийн бодисын зарцуулалтын тайлан

2022.12.27

д/д	Химийн бодисын нэршил/төмбөг			Хэмжих нэгж	8 сар				9 сар			
					Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Хүхрийн хүчил	Sulfuric Acid	H2SO4	тн	0	243.02	0.0	243.02	243.02	122.74	358.606	7.15
2	Lix 984NC	Lix 984NC	Хольц	тн	0	0	0	0	0	0	0	0
3	Кобальтын сульфат	Cobalt sulfate	CoSO4*7H2O	кг	0	2,400.00	-	2400.0	2400	0	720.00	1,680.00
4	Гуарфлос 66 /Vecosol FLW	Guarflor-66	C2H2ClNNaO5S	кг	0	2,800.00	-	2800.0	2800	0	200.00	2,600.00

д/д	Химийн бодисын нэршил/төмбөг			Хэмжих нэгж	10 сар				11 сар			
					Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Хүхрийн хүчил	Sulfuric Acid	H2SO4	тн	7.15	295.89	293.34	9.70	9.70	298.85	190.70	117.86
2	Lix 984NC	Lix 984NC	Хольц	тн	0	74.70	7.20	67.5	74.70	0	6.30	68.40
3	Кобальтын сульфат	Cobalt sulfate	CoSO4*7H2O	кг	0	2,400.00	-	2400.0	2400	0	720.00	1,680.00
4	Гуарфлос 66 /Vecosol FLW	Guarflor-66	C2H2ClNNaO5S	кг	0	2,800.00	-	2800.0	2800	0	200.00	2,600.00

д/д	Химийн бодисын нэршил/төмбөг			Хэмжих нэгж	12 сар				Нийт			
					Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
1	Хүхрийн хүчил	Sulfuric Acid	H2SO4	тн	117.86	477.99	359.65	236.20		1,438.49	1,202.29	236.20
2	Lix 984NC	Lix 984NC	Хольц	тн	68.40	0	3.60	64.80		74.70	17.10	57.60
3	Кобальтын сульфат	Cobalt sulfate	CoSO4*7H2O	кг	1680	0	560.00	1,120.00		2,400.00	1,280.00	1,120.00
4	Гуарфлос 66 /Vecosol FLW	Guarflor-66	C2H2ClNNaO5S	кг	2600	0	25.00	2,575.00		2,800.00	225.00	2,575.00

Тайлан гаргасан. Лабораторын эрхлэгч **Э.Азаяа**



“Ээс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

9.2. Химийн бодистой харьцах ажилтны сургалтад холбогдох ажилчдыг хамруулах

Ш.Отгонбилэгийн нэрэмжит “Шинжлэх ухаан технологийн их сургууль”-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу химийн бодистой харьцаж ажиллаж буй нийт ажилчдыг “Химийн бодисын аюулгүй ажиллагаа” сургалтад хамруулсан ба шалгалтад тэнцсэн ажилчдад 3 жилийн хугацаатай сертификат олгогдсон юм. Ажилчдыг аюул осолгүй ажиллуулах, хяналтыг сайжруулах зорилгоор 24 цагийн ХАБЭА-н ажилтан ээлжээр ажилладаг бөгөөд өдөр бүрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, өдөр тутмын наряд зааварчилгаа, шинэ ажилтны ХАБЭА-н сургалт, ХАБЭА-н давтан зааварчилгаанд хамруулан тухай бүр нь ХАБЭА-н дүрэм, журам стандартыг мөрдүүлж мөрдүүлж аюулгүй ажиллаж байна.

Хүснэгт-111. 2023 онд химийн бодисын сургалтад хамрагдсан ажилчдын бүртгэл.

Зураг-55. Химийн бодисын сургалт, ШУТИС

Хичээлийн сэдэв	Цаг	Хичээл багшийн нэр
2022 оны 08-р сарын 12		
Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, дүрэм, журам, олон улсын конвенц	08 ⁰⁰ – 09 ⁰⁰	Чаварын хяналтын хэлтсийн инженер М.Даваажан
Химийн бодисын таних тэмдэг, Ангилал хааг шошго		
Хорт бодисыг илрүүлэх, ангилах, бэлтгэхэд тавигдах ерөнхий шаардлага	09 ⁰⁰ – 10 ⁰⁰	
Химийн хорт болон аюултай бодисын ашиглах хадгалах тэвэрхэх уетгах журам		
Завсарлага 10 минут		
Хор судлалын ерөнхий ойлголт	10 ⁰⁰ – 11 ⁰⁰	Чаварын хяналтын хэлтсийн лабораторийн эрхлэгч Х.Билэгэ
Химийн бодисын өртөгтөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөнийг үнэлэхэд ашиглагдаж зөвшөөрөгдөх дээд хэмжээний талархи ойлголт		
Химийн бодисын бүртгэл менежмент	11 ⁰⁰ – 12 ⁰⁰	Чаварын хяналтын хэлтсийн чаварын менежмент О.Тувишцэнгэ
Үдийн завсарлага 12⁰⁰ – 14⁰⁰		
Ажлын байранд ашиглахыг зөвшөөрсөн химийн хорт бодисын хор аюул	14 ⁰⁰ – 15 ⁰⁰	Чаварын хяналтын хэлтсийн лабораторийн эрхлэгч Б.Анхбаяр
Хорт хийнүүд, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө		
Завсарлага 10 минут		
Химийн аюултай бодис	15 ⁰⁰ – 16 ⁰⁰	Дуулам шалгалтын станцийн лабораторийн эрхлэгч Д.Төгсбаяр
Химийн хорт болон аюултай бодисын Хор Аюулын Лавлах Мэдээлэл (ХАЛМ)	16 ⁰⁰ – 16 ⁰⁰	Чаварын хяналтын хэлтсийн инженер М.Байгальмаа
ШАЛГАЛТ 16⁰⁰-17⁰⁰		

ХАБЭА-н сургалтын баг





9.3. Химийн бодисын асгаралт үүсвэл саармагжуулалт хэрхэн хийх талаар журам боловсруулж мөрдөх, химийн бодисыг цэвэрлэх, саармагжуулах арга хэмжээ авах, багаж хэрэгсэлтэй байх

“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн “Катодын зэс боловсруулах үйлдвэр” /цаашид үйлдвэр гэх/-н үйл ажиллагааны явцад болон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, хүдэр тээвэрлэлт болон бусад холбогдох үйл ажиллагааны үүсэж болзошгүй асгаралт (электролит уусмал, хүчил, шүлт, химийн бодис агуулсан органик уусмал, аюултай хог хаягдлын сав баглаа боодол, түлш, тос, масло, тосолгооны материалууд, ахуйн шингэн, хатуу хог хаягдал, барилгын хатуу хог хаягдал, цемент) зэргийн асгаралтын үед авах арга хэмжээг шуурхай зохион байгуулж байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахад энэхүү журмын зорилго оршино. Үйлдвэрийн бүсэд үүсэж болзошгүй асгаралтуудыг дараах байдлаар саармагжуулахаар бэлтгэл бэлэн байдлын хангаж ажилладаг.

Хүснэгт-23. Асгаралт саармагжуулах

№	Асгаралтын нэр	Саармагжуулах арга	Саармагжуулах бодис	Бэлэн байдал, нөөц
1	Электролит уусмал/хүчил, шүлт, химийн бодис, $CuSO_4$)	Хими, механик	Сода-н уусмал, шохойн уусмал, шингээгч элс, арчих материал	1.0тн
2	Аюултай хог хаягдлын сав баглаа боодол	механик	Харьяалах нэгжид зөрчил аргах шаардлага хүргүүлнэ зөрчлийг арилгуулж ажиллана.	Аюултай хол хаягдлын агуулах
3	Түлш, тос, масло, тосолгооны материалууд	Хими, механик	Үүссэн асгаралтыг хусаж цэвэрлэн асгаралт саармагжуулах талбайд байршуулж саармагжуулна.	Аюултай хог хаягдлын агуулах 5.0тн
4	Ахуйн шингэн	хими	Хлорамины шохой, хлорын уусмалаар	200.0кг



“Ээс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

			талбайг ариутгана.	
5	Цемент	механик	Харьяалах нэгжид зөрчил аргах шаардлага хүргүүлнэ зөрчлийг арилгуулж ажиллана.	Хог хаягдлын нэгдсэн цэг

Зураг-56. Асгаралт саармагжуулах элс, шохой



“Ээс эрдэнийн хувь” ХХК-ийн
Гүйцэтгэх захирлын 20... оны... сарын...-ны өдрийн
... тоот тушаалын Хөргөлдөөр хяналтын

АСГАРАЛТ БҮРТГЭХ ХУУДАС

Мэдээтэйг бэлтгэнэ: _____

Асгаралт болсон өдөр сар өдөр:	Харьяалагдах хэлтэс/ Гэрээт компани:	
Асгаралтын талбар мэдээлсэн ажилтны овог нэр:		
Утас:	Албан тусгаал:	
<input type="checkbox"/> ХММЭ-н талбай <input type="checkbox"/> Үйлдвэр /SX/ <input type="checkbox"/> Үйлдвэр /EW/	<input type="checkbox"/> ШТС <input type="checkbox"/> Усны их үүсвэр <input type="checkbox"/> Технологийн тэм	
<input type="checkbox"/> Парком талбай <input type="checkbox"/> Лаборатори	<input type="checkbox"/> Нуруулам уулзгалын талбай <input type="checkbox"/> Буудал	
Бохирдсон хэрэгний хэмжээ: Асгаралтын байршил /байгцар:/ Байршилын талаарх нэмэлт тайлбар:	Асгаралт болсон цаг:	
Асгаралт үүсгэсэн эх үүсвэрийн мэдээлэл		
Тонног төлөөрөгчийн төрөл:	Тайлбар:	Тонног төлөөрөгчийн ID:
Асгаралт үүсгэж хуртгах үйл явц /дотор ажлаа гүйцэтгэж байх үед:/		
Асгаралт үүсгэн шалтгаан: <input checked="" type="checkbox"/> Шинэ ажил эхлэв <input type="checkbox"/> Техник, тоног төхөөрөмжийн хямралтай дагуу ажиллагаа <input type="checkbox"/> Силлавар бэлтгэж ажиллагаа <input type="checkbox"/> Бууруу таслах ажиллагаа <input type="checkbox"/> Суурьд хангалтгүй <input type="checkbox"/> Жайргүйч сүлэрсн, дамжуулах ажилтай задарсан <input type="checkbox"/> Бусад	Тайлбар	
Байдал орчны гэрээгээр хяналтын бэлтгэнэ: _____		
Асгаралтын бүтээгдэхүүний төрөл: <input type="checkbox"/> Шингэн <input type="checkbox"/> Асгаралтын бүтээгдэхүүн:	<input type="checkbox"/> Хэмжээ (м. кв. м): <input type="checkbox"/> Хатуу Асгаралтын бүтээгдэхүүн:	<input type="checkbox"/> Хэмжээ (м. кв. м): <input type="checkbox"/> Хатуу Асгаралтын бүтээгдэхүүн:

Хуудас 1/2

“ЭЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-НИЙ ХОДВӨЛӨӨРНИЙ АЮУЛ ВУЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЭТГЭС

Батлан, “Ээс эрдэнийн хувь” ХХК-ийн Гүйцэтгэх захирал **Б. Монголбаатар**

“ЭЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-НИЙ “АСГАРАЛТ БҮРТГЭХ, СААРМАГЖУУЛАХ” ЖУРГАМ

ЭХ. ХАБЗАБО-01/008

АГУУЛГА	НЭР, АЛБАН ТУШААЛ	ОГНОО	ТАРЫН ҮСЭГ
Боловруулсан	БО-ны мэргэжлээр Н.Монголбаатар	2023.06.05	
Хяналсан	ХАБЗАБОХ-ийн менежер Н.Батболд	2023.06.05	
Өөрчлөлт			

Орлон аймаг 2023 он

1



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

9.4. Ажилчдыг нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хор саармагжуулах бүтээгдэхүүнээр хангах

Манай компани нь Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн төвшингөөс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна” хэмээн заасны дагуу жилийн төсвийн 1.5 хувийг зөвхөн ХАБЭА-ын зардалд төсөвлөн зарцуулдаг.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.1 дэх заалт, Хөдөлмөр сайдын 2015 оны А/223 дугаар тушаалаар батлагдсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”-ын дагуу “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн Катодын зэс боловсруулах үйлдвэрийн “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайлан”-г гүйцэтгүүлсэн ба хортой хүнд ажлын байруудад ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, дэмжихэд чиглэсэн хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт-24. Ажилчдын эрүүл мэндийг дэмжих, хор саармагжуулах бүтээгдэхүүн

№	Бүтээгдэхүүний нэр	Огноо	Тоо ширхэг
1	Чацарганын шүүс	1 сар	2,880.0
2	Чацарганын шүүс	2 сар	2,880.0
3	Чацарганын шүүс	3 сар	2,880.0
4	Жанчивлан		2,160.0
5	Жанчивлан	4 сар	2,160.0
6	Луувангийн шүүс		2,100.0
7	Луувангийн шүүс	5 сар	1,500.0
8	Гадилтай аарцны ундаа		500.0
9	Зэрлэг жимсний ундаа		1,500.0
10	Луувангийн шүүс	6 сар	1,500.0
11	Гадилтай аарцны ундаа		1,000.0
12	Жанчивлан	7 сар	500.0
13	Луувангийн шүүс		1,000.0
14	Гадилтай аарцны ундаа		500.0
15	Луувангийн шүүс	8 сар	500.0
16	Жанчивлан		500.0
17	Мультвитамин		1,000.0
18	Цэнэг	9 сар	1,100.0
19	Цэнэг		2,400.0
20	Цэнэг	10 сар	2,400.0
Нийт			30,960.0

Зураг-57. Ажилчдын нэг бүрийн хамгаалах хэрэгсэл



ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ

СОНСГОЛ ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ
ЧАНГА ДУУЧИМЭЭНЭЭС ХАМГААЛНА

АМЬСГАЛЫН ЗАМЫГ ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ
ТООС БОЛОН БУСАД ХОРТ ХИЙНЭЭС ХАМГААЛНА

АЖЛЫН БЭЭЛИЙ ТАНЫ ГАРЫГ ГАМТЭЛЭЭС ХАМГААЛНА

АЖЛЫН ГУТАЛ
ТАНЫ ХӨЛ ДЭЭР ЯМАР НЭГ ЗҮЙЛ УНААЖ ГЭМТЭХЭЭС ХАМГААЛНА

ТОЛГОЙ ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ
ТАНЫ ТОЛГОЙ ДЭЭР ЭД ЗҮЙЛ УНАХАД ХАМГААЛНА

АЖЛЫН ШИЛ
ТАНЫ НҮДРҮҮ ТООС ШОРОО, ЖИЖИГ ХОТ ОРОХООС ХАМГААЛНА

ЦАЦРУУЛАГЧТАЙ ХУВЦАС
БУСАД АЖИЛЧИД ҮЗЭГДЭХ ОРЧИН БАГАТАЙ ҮЕД ТАНЫГ ХАРАХ БОЛГОМЖЫГ НЭМЭГДҮҮЛНЭ

Зураг-58. Ажилчдад олгож буй эрүүл мэнд дэмжих бүтээгдэхүүн.





9.5. Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж (утаа зайлуулах систем, галын автомат систем, ус хангамж, галаас хамгаалах хаалт, хаалга, г.м)- ийг ашиглалтын байнгын бэлэн байдалд байлгах

Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм” болон ХАБЭА-н нийтлэг дүрмийн 15 дахь хэсэг буюу Галын аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Объектын гал түймэр нь бүх төрлийн барилга байгууламжид гарах боломжтой учраас үйлдвэрийн бүсэд байгаа бүх барилга байгууламж гал түймрийн эрсдэлийг тооцож гал түймрийн гаралт, түүнээс учрах эрсдэлийг багасгахын тулд зөв менежментийг хэрэгжүүлэн, гал түймэр гарах, тархах, түүнтэй тэмцэх асуудалд нөлөөлж буй бүх хүчин зүйлүүдийг тодорхойлж, гал гарсан бол богино хугацаанд хохирол багатай унтраах нөхцөлийг бүрдүүлэх, гал унтраах бэлтгэл, бэлэн байдлыг хангах явдал чухал юм.

Галын автомат систем нь ус-хөөсний систем бөгөөд хүний оролцоогүйгээр ажилладаг, шаардлагатай тохиолдолд хяналтын мониторингоос залгаж салгах боломжтой бүрэн автомат систем юм. Галын автомат систем нь Усан танк, хөөсний танк, дренчер, хагас болон бүтэн хөөсний генератор, цахилгаан генератор, удирдлагын монитор, дуут дохиолол, программчлал, бүрэн автомат хавхлаг зэргүүдээс бүрддэг.

Зураг-59. Үйлдвэр доторх галын автомат систем





Бага хэмжээний галыг гал унтраах анхан шатны багаж хэрэгслээр унтраах бөгөөд гал нь хараа хяналтаас гарсан тохиолдолд гал унтраах автомат систем нь автоматаар ажиллаж унтраана.

Зураг-60. Галын аюулгүй байдал, бэлтгэл бэлэн байдал, практик сургалт







9.6. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, галын аюулгүй байдлын дүгнэлт зэргийг Орхон аймгийн Онцгой байдлын газраар батлуулах.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ нь хүн ам, эд хөрөнгө, амьжиргааны хэрэгсэл, тэдгээрийн хамаардаг хүрээлэн буй орчинд заналхийлж эсвэл хохирол учруулж болзошгүй гамшгийн аюул, эмзэг байдалд дүн шинжилгээ хийж, эрсдэлийн мөн чанар, хэмжээ, далайцыг тодорхойлох явц юм. Энэ утгаараа гамшгийн эрсдэлийн үнэлгээ нь гамшгийн эрсдэлийг бууруулах цаашлаад гамшгаас хамгаалах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх бодлого, шийдвэр төлөвлөгөөний үндэс болдог. Эрсдэлийг үнэлэх нь байгалийн аюулт үзэгдэл ба техник технологийн холбоотой осол, тэдгээрийн үүсгүүрүүдийн газар зүйн байрлал, аюулын цар хүрээ нийгэм эдийн засаг, эрсдэлд орох объектуудын эмзэг байдлыг тогтоож өгдөг. Гамшийн эрсдэлийн үнэлгээ нь байгалийн ба техникийн гаралтай аюултын хөнөөл, хохирлыг багасгахад чиглэсэн ажлыг төлөвлөх, оновчтой шийдвэр гаргаж гамшгаас хамгаалах ажлыг үр дүнтэй зохион байгуулахад суурь нөхцөл болдгоороо өндөр ач холбогдолтой.

Зураг-61. Гамшигийн эрсдэлийн үнэлгээний тайлан, батлагдсан нүүр





“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний талаарх заалт, түүнтэй уялдуулан гаргасан Монгол улсын Засгийн газрын 190 дүгээр тогтоол, Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зураг-62. Батлагдсан тайлан, төлөвлөгөө, дүгнэлт

ОБЕГ-ын дэргэм 2018 оны 07 дугаар 10-ны өдөр А/229 дугаар тушаалаар өндүртэй хэвцэрт

БАТЛАВ:
“ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-ийн,
Гүйцэтгэх захирал
Б.МЭНХБААТАР

ЗӨВШӨӨРСӨН:
ОБЕГ-ын дэргэдэх УУХУ-ийн
АВРАХ ӨН ДҮГЭР АНГИЙН ДАХИРАГЧ
ХУРАЦЛАА Д.ГАНТУША



**“ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-ийн КАТОДЫН
ЗЭСИЙН ҮЙЛДВЭРИЙН 2023 ОНЫ АЮУЛЫН ҮЕД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**


ХЯНАСАН:
УУЛ УУРХАЙ АВРАХ АНГИЙН ТЕХНИК, АВРАХ АЖИЛЛАГААНЫ УДӨРДАГЧ,
АХМАД Д.БАЯРЖАРГАЛ

ХЯНАСАГЧЭС ЭРДЭНИЙН ХУВЬ ХХК-ийн
ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА Ц.АРИУНБОЛД

БОЛОВСРУУЛСАН:
ХОДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН
МОНГОЛЫН МОНГОЛЫН Ч.БУЯН-ОЧИР


2023 он

Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө Хуудал I



**АЖЛЫН БАЙРНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
(Эцсийн хувилбар)

Захиалагч: “ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК
Гүйцэтгэгч: “ТҮМЭН ТЭРЭМ” ХХК



Тайлангийн дугаар: WCA 23001

2023 он

ОБЕГ-ын дэргэм 2019 оны 12 сарын 12-ны А/388 тоот тушаалаар 3-р хэвцэрт

БАТЛАВ:
“ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал
Б.МЭНХБААТАР

**“ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-ийн ГАМШГААС
ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**



Боловруулсан: 2023 он 01 сар 31 өдөр
Тодотгосон: 2023 он 01 сар 01 өдөр
2023 он 01 сар 01 өдөр
2023 он 01 сар 01 өдөр
2023 он 01 сар 01 өдөр

ХЯНАСАН:
ГАМШГААС ХАМГААЛАХ, ТӨЛӨВЛӨЛТ, БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТЭН,
ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ, ХОШГУУЛ
Ц.ОНОНТАЛ

БОЛОВСРУУЛСАН:
ХОДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЖИЛТАН
Ж.ЭРЭНЭЭВРАХ

ОРХОН АЙМАГ
2023 ОН



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



9.7. Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэлтэй байх

Монгол улсын Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3 дахь заалтыг үндэслэн Орхон аймгийн УЦУОШТ-тэй байгуулсан 2023 оны 1 сарын 5-ны өдрийн ҮҮГ-23/08 тоот “Үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу баталгаат мэдээллээр байнга хангагдаж үйл ажиллагааг цаг уурын мэдээтэй уялдуулан осол эрсдэлгүй ажиллаж байна. Тусгай хэрэгцээний мэдээ:

- Хоногийн урьдчилсан мэдээ /өдөр бүр 14³⁰-15⁰⁰ цагт /
- 5 Хоногийн урьдчилсан мэдээ /5 хоногийн давтамжаар тухайн өдрийн 14³⁰-15⁰⁰ цагт/
- 7 Хоногийн урьдчилсан мэдээ / Даваа гариг бүрийн 14³⁰-15⁰⁰ цагт /
- Сарын урьдчилсан мэдээ / Сар бүрийн 28-нд 14³⁰-15⁰⁰ цагт /
- Улирлын урьдчилсан мэдээ/ Сар бүрийн 30-нд 14³⁰-15⁰⁰ цагт /
- Анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээ /тухай бүр нь/
- Цаг уурын тодорхойлолт, лавлагаа, хур тунадасны мэдээ /тухай бүр нь/

Агаар, ус, хөрс, ахуйн бохир усны шинжилгээ, ахуйн бохир усны шинжилгээг MNS ISO IEC 17025 стандартаар итгэмжлэгдсэн лабораторид гүйцэтгүүлэн ажиллаж байна.

Хүснэгт-25. Талуудын мэдээлэл

Захиалагчийн хувьд:		Гүйцэтгэгчийн хувьд:	
Нэр:	“Зэс эрдэнийн хувь” ХХК	Нэр:	Орхон аймгийн “Ус цаг уур орчны шинжилгээний төв”
Хаяг:	Орхон, Баян-Өндөр, 11-р баг, Цагаанчулуут, 7 хороолол,	Хаяг:	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан баг, Тосгон Эрдэнэт



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

	Спорт цогцолбор		хивс ХК-ний баруун талд
Утас:	70358008, 70358009	Утас:	99782558
И-мэйл:	info@zes-erdene.mn	И-мэйл:	orkhon.namem@gov.mn http://orkhon.tsag-agaar.gov.mn/

Зураг-63. Тусгай хэрэгцээний мэдээ

Reply Reply All Forward IM
 Mon 10/30/2023 1:09 PM
 Erdenet ZMED <zmederdenet@gmail.com>
 Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс 7 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээ хүргэж байна.

To: Badka_37@yahoo.com; boldbaatar1984@yahoo.com; d_ara2009@yahoo.com; munkhnasan2005@yahoo.com; dpurev2005@yahoo.com; s.bayalag@yahoo.com; oyun_515@yahoo.com; bmb_sbs@yahoo.com; ganaa368025@yahoo.com; baigal_078@yahoo.com; sainaa_3@yahoo.com; baaska_88sh@yahoo.com; tugs_naim@yahoo.com; orhot_80@yahoo.com; emer.orkhon81@yahoo.com;

2023 оны 10 сарын 31-ээс 11 сарын 06-ыг хүртэлх 7 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээ

31, 01-нд бага зэргийн, 02, 03, 04, 06-нд цас орно. Салхи ихэнх хугацаанд 5-10 м/с, 11 сарын 04-нд үе үе ширүүсч зөөлөн цасан шуурга шуурна. Шөнөдөө -8...-3 градус, өдөртөө 4...9 градус, 11 сарын 02-оос өдөртөө бага зэрэг сэрүүсч -2...3 градус байна.

**ОРХОН АЙМГИЙН
 УС ЦАГ УУР ОРЧНЫ
 ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
 ТОДОРХОЙЛОЛТ**
 61021 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
 Баянцагаан баг, Утас/Факс: 70355859
 Цахим шуудан: orkhon@namem.gov.mn
 2023.11.03 № 185

"ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ" ХХК-Д

Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутгаар 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэлх хугацааны хур тунадасны мэдээг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай

ДАРГА *[Signature]* С.ОТГОНБААТАР
 D:\Бичиг хэрэг\ТотAS хуучин.docx

"Зэс эрдэнийн хувь" ХХК, УЦУОШТ-ийн хооронд хийсэн 2023 оны 01-р сарын 06-ны өдрийн УТГ-23/016 тоот гэрээний хавсралт

Ажлын үр дүнг хүлээн авсан акт

2023 оны 12-р сарын 05 өдөр

Д/д	Ажлын нэр төрөл	Хэмжих нэгж	Гэрээ ёсоор		Үнэ	Нийт үнэ
			тоо	тоо		
1	Хоногийн урьдчилсан мэдээ	ш	365	365	6.000	2.190.000
2	5 хоногийн урьдчилсан мэдээ	ш	73	73	7.000	511.000
3	7 хоногийн урьдчилсан мэдээ	ш	52	52	8.000	416.000
4	Сарын урьдчилсан мэдээ	ш	12	12	5.000	60.000
5	Улирлын урьдчилсан мэдээ	ш	4	4	5.000	20.000
6	Богир усны шинжилгээний дүн	ш	3	3	36.500	109.500
7	Усны шинжилгээний дүн	ш	12	12	40.000	480.000
8	Агаарын шинжилгээний дүн	ш	6	6	18.500	111.000
9	Хөрсний шинжилгээний дүн	ш	6	6	56.500	341.400
	Бүгд					4.236.900

Шийдвэр:

Комиссын гишүүд: Ажил гүйцэтгэгч: *[Signature]* /Н.Энхмаа/
 БОШП-ын ус, хөрсний инженер: *[Signature]* /Н.Энхмаа/
 Хүлээлгэн өгсөн: *[Signature]* /Ц.Энхтөгс/
 БОШП-ын чаварын менежер: *[Signature]* /Ц.Энхтөгс/
 Алт дүгэсн: *[Signature]* /Ц.Мэндбаяр/
 Хүлээн авсан мэргэжилтэн: *[Signature]* /Ц.Мэндбаяр/

Орхон аймаг Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт орсон 2023 оны 01 сарын 01-ээс 11 сарын 03-ыг хүртэлх хугацааны хур тунадасны түүвэр

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын 2023 оны 11 дугаар сарын 03-ны өдрийн 185 дугаар тулган бичгийн хавсралт

Сар өдөр	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI
1	0.0			0.5		8.6	13.2		0.5		0.0
2				0.2		0.0	0.0	20.3		3.7	0.4
3							23.7		5.1		
4					0.4	0.3	6.2		1.1		
5	0.0			0.0		0.0	10.2				
6						0.0	5.8	36.8	2.2	8.4	
7						0.1	1.2	0.0	15.1	1.4	
8						0.0			0.0		
9				2.0	0.0	0.0	0.4	4.9	1.1		
10				0.3	0.3	12.0	4.2				
11				0.2		2.3	0.0	8.9	0.0	3.7	
12	1.2						4.9				
13	0.0	0.0				1.3	1.0	21.9	0.4		
14				0.3		10.1	1.0	8.6	7.1		
15				0.9		0.6	0.0				
16					0.0	0.0	0.0		15.9		
17				0.4		0.1	12.3	0.0	22.6	4.0	
18	0.6				0.7	0.6	1.6	11.5		1.1	
19	1.6					0.0	1.1	0.0			
20						0.5	0.0		7.3	0.0	
21	0.6			5.5		0.5	16.0	3.2	0.0		
22	0.2					0.0	0.0				
23						0.7	1.0	8.9			
24					0.8	0.0	7.4	1.3	0.9		
25						0.9	12.4	3.6		10.1	
26						0.0	2.9		0.0		
27		0.2		1.5		0.5	1.4	0.0		0.0	
28							0.4		0.0		
29									11.6		
30						9.7				0.0	
31						31.8		0.0		1.9	
										0.3	



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

- 10.2.8. хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх;
- 10.2.9. эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх;
- 10.2.10. энэ хуулийн 9.4.12-т заасан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;
- 10.2.11. барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах;
- 10.2.12. хог хаягдлын талаарх сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх;
- 10.2.13. хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах;
- 10.2.14. хог хаягдлын талаарх хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;
- 10.2.15. хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;
- 10.2.16. аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;
- 10.2.17. үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;
- 10.2.18. аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах, аюулгүй ажиллагааг хангах.
- 10.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараах үйл ажиллагааг хориглоно:
- 10.3.1. хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях;
- 10.3.2. нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях;
- 10.3.3. хог хаягдлыг ил задгай шатаах;
- 10.3.4. гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах;
- 10.3.5. хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;
- 10.3.6. аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах;
- 10.3.7. нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх.

10.1. Аюултай хог хаягдлыг бүртгэлжүүлэн хадгалах, гэрээг мэргэжлийн байгууллагатай хийж хог хаягдлыг шилжүүлэх

“Цэцүүх трейд” ХХК-тай байгуулсан 2022 оны 10 сарын 31-ний өдрийн Ш-22/125, АГГ-22/136 тоот “Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ”, 2022 оны 10 сарын 31-ний өдрийн Т-22/074, АГГ-22/137 тоот “Тээвэрлэлтийн гэрээ”-ний дагуу аюултай хог хаягдлыг хуулийн хугацаанд хадгалан



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

хүлээлгэн өгч устгуулж байна.

Зураг-64. Аюултай хог хаягдлын бүртгэл гэрээ

ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

Огноо: 2022 оны 10 сарын 31
Гэрээний дугаар: Т-22/094
АГГ-22/137

Хүлээн авагч: “Цэцүүх Трейд” ХХК
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо 116000, Зэсэрдэнийн орчны өмчлөлтийн байр “Цэцүүх” офис, үйлчилгээний тээвэр
Утас: +976 9117977, +976 9118682
Нэгж үйлчилгээний тээвэр: 206021
Холбоо барих: info@tsetsuuh.mn

Үүсгэгч: “Зэс эрдэнийн хувь” ХХК
Хаяг: Монгол Улсын Улаанбаатар хот, Баянгол дүүрэг МУЭСЦО 311 тусгай
Утас: +976 7033008, +976 8810586
Эл. хаяг: info@zesserdniimn.mn
Регистрийн дугаар: 538802
Холбоо барих: info@zesserdniimn.mn

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

Огноо: 2022 оны 10 сарын 31
Гэрээний дугаар: Ш-22/136
АГГ-22/136

Хүлээн авагч: “Цэцүүх Трейд” ХХК
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо 116000, Зэсэрдэнийн орчны өмчлөлтийн байр “Цэцүүх” офис, үйлчилгээний тээвэр
Утас: +976 9117977, +976 9118682
Нэгж үйлчилгээний тээвэр: 206021
Холбоо барих: info@tsetsuuh.mn

Үүсгэгч: “Зэс эрдэнийн хувь” ХХК
Хаяг: Монгол Улсын Улаанбаатар хот, Баянгол дүүрэг МУЭСЦО 311 тусгай
Утас: +976 7033008, +976 8810586
Эл. хаяг: info@zesserdniimn.mn
Регистрийн дугаар: 538802
Холбоо барих: info@zesserdniimn.mn

“ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-ИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ТАЙЛАН

Байр орчн шалгуур хуульчилсан сайтан 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн А/21 дугаар тушаалын 3 дугаар хэсгээр

2023 он
У-001533
“Зэс эрдэнийн хувь” ХХК
901179093

Монгол улс, Орхон аймаг, Баян-Өлгий сум, Уурхайн баг, 3-р хороолол, 2-5 тоот

7. Үүсгэгч аюултай хог хаягдлын мэдээлэл

№	Код	Аюултай хог хаягдлын нэр	Үүсгэгч хэмжээ	Хэмжих нэгж/кг
1	1 5 0 1 0 9	Хүрлийн хууцгийн сав (1.8тн)	26.0тн	20.8
2	1 5 0 1 0 9	Хүрлийн хууцгийн сав (1.0тн)	106.0тн	3,498.0
3	1 5 0 1 0 9	Лх. 98АМС-ийн сав (1.0тн)	26.0тн	858.0
4	1 5 0 1 0 9	Кобальтын сульфид (шугуй-50кг)	52.0тн	26.0
5	1 5 0 1 0 9	Гуарфлекс (шугуй-25кг)	22.0тн	5.5
6	1 5 0 1 0 1	Химийн болгоомор бохирдсон ариуруу	0.67тн	674.0
7	1 3 0 5 0 1	Хаягдал тос (Тууш, тоос, диндэв)	2.9тн	2,500.0
Нийт				7,582.3

8. Аюултай хог хаягдал тээвэрлэгчийн тээвэрлэгчийн мэдээлэл

№	Тээвэрлэгч аж ахуй нэгжийн нэр	Бүртгэлийн дугаар
1	“Цэцүүх трейд” ХХК	Б 0 0 0 0 0 7

9. Аюултай хог хаягдал устгуулагч байгууллагын мэдээлэл

№	Аж ахуй нэгжийн нэр	Бүртгэлийн дугаар	Үүсгэгч хэмжээ	Хэмжих нэгж
1	Цэцүүх трейд ХХК	У 0 0 0 1 1 2 3	4.1	тн
2	Мошгоно Ойв ХХК	У 0 0 0 1 2 1 0 6	2.5	тн

Тайлбар: Мошгоно ойв ХХК-д олоогоор хаягдал хүргэгчид өгөгдөж байна. “Цэцүүх трейд” ХХК-д олоогоор аюултай хог хаягдал шилжүүлэгч бөгөөд аюултай хог хаягдлыг хүчинг гурвалын туршилоо хийж байна.

10. Үүсгэгч хог хаягдал устгах, дахин боловруулах үйл ажиллагаа явуулахаар

11. Тайвны гаргасан албан тушаалын мэдээлэл

Гарын үзэг, тамга	Огноо, албан тушаал	Огноо
Ц.Ариунболд	“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн Үйлдвэр технологийн газрын дарга	2023.07.01
Ц.Мөнхбаяр	“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн Байгаль орчны менежментийн	2023.07.03

№ 000575

Дагалдах бичгийн дугаар:
/шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ/

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:
Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: 001533
Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: “Зэс эрдэнийн хувь” ХХК

2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:
Овог нэр: Ц. Цэндбаяр
Албан тушаалтан: Б.А. н.с. /диррагийн
Гарын үзэг: [Холбоо барих]
Огноо: 2023 он 07 сар 05 өдөр

3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:
1) Тээврийн хэрэгслийн улсын дугаар: 77-86 4Е0. Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:

4. Аюултай хог хаягдлын талварын мэдээлэл:

Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангиллын зэрэглэл	Савлаганы бүлэг	Савны дугаар	Төрөл	Хэмжээ	Нэгж /кг	Эсвэл/ш	Аюултай хог хаягдлын код
1. Дамжирсан агцур, бтмш	А	Битүү			800	кг		150102
2. Мушгач сав	А	Битүү	HDPE		26	кг		150109
3. ИВС тасал	Х	Дуусгай	HDPE		7	ш		150109

3. Тээвэрлэх үед анхнаарх нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:

5. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч:
1) Овог нэр: Ц. Цэндбаяр
Гарын үзэг: [Холбоо барих]
2023 он 07 сар 05 өдөр

6. Үл зохихлол:

7. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:
Аж ахуйн нэгжийн нэр: ЦЭЦҮҮХ ТРЕЙД ХХК
Цэцүүх трейд ХХК бүртгэлийн дугаар: У-001123

Аюултай хог хаягдлыг хүлээн авсан.
Овог нэр: Цэцүүх трейд ХХК
Албан тушаал: [Холбоо барих]
Гарын үзэг /тамга/ [Холбоо барих]
Огноо: 2023 он 07 сар 05 өдөр

“Зэс эрдэнийн хувь” ХХК болон “Цэцүүх трейд” ХХК-ийн хооронд 2022 оны 10 сарын 31-ний өдөр байгуулсан Ш-22/125 АГГ-22/136 тоот “Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ”-ний дагуу



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, 116-р тогтоол, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалыг удирдлага болгон аюултай хог хаягдлыг шилжүүлэв.

Зураг-65. Аюултай хог хаягдал хүлээлгэн өгч буй байдал



10.2. Орон нутгаас зарлаж буй бүх нийтийн цэвэрлэгээнд идэвхтэй оролцож, Чингэл гол дагуух ахуйн хог хаягдлыг түүж цэвэрлэх

Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.6 дахь заалт: “Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд иргэн бүр оролцох



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

үүрэгтэй” хэмээн заасан байдаг. Үүний дагуу Орхон аймгийн БОАЖГ-аас зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээнд Чингэл голын сав дагууд нийт 181га талбайд 40 хүний бүрэлдэхүүнтэйгээр бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж 38м³ хог хаягдлыг цуглуулан нэгдсэн хогийн цэгт устгуулсан.

Зураг-66. Бүх нийтийн цэвэрлэгээ





“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

10.3. Хог хаягдлын гэрээ хийж ахуйн хог хаягдал, уурын зуухнаас гарах үнсийг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэх, дахивар хог хаягдлыг орон нутгийн дахивар цуглуулах, тээвэр ложистикийн төвд тогтмол өгч хэвших

Монгол Улсын Иргэний хуулийн 189, 343-358-р зүйл, “Хог хаягдлын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 10 дугаар зүйл дугаар зүйл, Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 03 тоот тогтоолыг тус тус үндэслэн Орхон аймгийн Хот тохижуулах газартай 2023 оны 07 сарын 01-ний өдрийн АГГ/23/086 тоот “Хог хаягдал дарж устгах гэрээ”-г байгуулсан.

Зураг-26. Ахуйн хог хаягдал дарж устгуулсан бүртгэл

Он сар өдөр	Байгууллагын нэр	Хог хаягдлын хаягдал м ³	Нэгж үнэ/төг	Нийт үнэ/төг
2023.01 сар	"Зэс эрдэнийн хувь" ХХК	84.0	11,500.00	966,000.00
2023.02 сар	"Зэс эрдэнийн хувь" ХХК	63.0	11,500.00	724,000.00
2023.03 сар	"Зэс эрдэнийн хувь" ХХК	96.0	11,500.00	1,104,000.00
2023.04 сар	"Зэс эрдэнийн хувь" ХХК	84.0	11,500.00	966,000.00
2023.05 сар	"Зэс эрдэнийн хувь" ХХК	84.0	11,500.00	966,000.00
2023.06 сар	"Зэс эрдэнийн хувь" ХХК	66.0	11,500.00	759,000.00
2023.07 сар	"Зэс эрдэнийн хувь" ХХК	48.0	11,500.00	552,000.00
2023.08 сар	"Зэс эрдэнийн хувь" ХХК	36.0	11,500.00	414,000.00
2023.09 сар	"Зэс эрдэнийн хувь" ХХК	24.0	11,500.00	276,000.00
2023.10 сар	"Зэс эрдэнийн хувь" ХХК	24.0	11,500.00	276,000.00
2023.11 сар	"Зэс эрдэнийн хувь" ХХК	1056.0	11,500.00	12,144,000.00
2023.12 сар	"Зэс эрдэнийн хувь" ХХК	36.0	11,500.00	414,000.00
Нийт		1,701.0		19,561,500.00

Дахивар хог хаягдлын ангилан ялгалт:

- “Зэс эрдэнийн хувь” ХХК “Витафит” групп-тэй бүтээгдэхүүн худалдан авалтын гэрээг байгуулан ажилладаг ба бүтээгдэхүүний шилэн савыг тус компанид буцаан ачуулдаг. Монгол улсын “Хог хаягдлын тухай” хуулийн 10 дугаар зүйл болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу ангилан ялгасан шилэн савыг Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг 3-р хороо, Үйлдвэрийн гудамж-1, Витафит групп-д 5000.0 ширхэг хүлээлгэн өгөв.
- “Зэс эрдэнийн хувь” ХХК нь Монгол улсын “Хог хаягдлын тухай” хуулийн 10 дугаар зүйл болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу ангилан ялгасан хуванцар хог хаягдлыг Орхон аймаг Баян-Өндөр сум Уртын гол баг, Баян зам 4-6 тоот хаягт байрлах “Төвхөн ананд” ХХК, Гүйцэтгэх захирал Ө. Хоролсүрэн-д 2570 ширхэг хүлээлгэн өгөв.

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/134 дүгээр тушаалаар зөвшөөрснөөр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 09-р сарын 19-ны өдрийн А/527. дугаар тушаалаар баталсан “Энгийн хатуу хог хаягдлын жилийн мэдээ” (3-БОХ-6.1) маягт, “Хог



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан хаягдлын дахин ашиглалт, боловсруулалтын жилийн мэдээ” (3-БОХ-6.3) маягт “Аюултай хог хаягдлын жилийн мэдээ” (3-БОХ-6.2) маягт болон БОАЖ-ын сайдын 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн А/21 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуух мэдээ тайлангуудыг гаргаж ажиллав.

Зураг-67. Хог хаягдлын ангилан ялгалт



Зураг-68. Дахивар хог хаягдлын ангилан ялгалт, хадгалалт





10.4. Машин техникийн үйлчилгээ, эвдрэл гэмтэл зэргээс асгаралт үүссэн дариуд бүртгэлжүүлэн саармагжуулах арга хэмжээ авах


Манай компани нь автомашин, хүнд машин механизмуудын засвар үйлчилгээг засварын байранд хийж гүйцэтгэж байна. Автомашины засварын байр болон хүнд машин механизмын засварын байрын барилгыг тусад барилга байгууламжаар шийдсэн нь засвар үйлчилгээнээс гадаад орчинд асгаралт үүсэхээс бүрэн сэргийлсэн.

Зураг-69. Хүнд машин механизмын засвар үйлчилгээ





Зураг-70. Автомашинуудын засвар үйлчилгээ



10.5. Эрх бүхий байгууллагатай "Хаягдал тос" шилжүүлэх гэрээ байгуулж аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад шилжүүлэх



“Зэс эрдэнийн хувь” ХХК болон “Монпити ойл” ХХК-ийн хооронд байгуулсан 2023 оны 1 сарын 15 -ний өдрийн АГГ-21-051 тоот “Аюултай хог хаягдал цуглуулах тээвэрлэх устгах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид аюултай хог хаягдал шилжүүлэн өгөх гэрээ”-ний дагуу Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1,2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал, Хог хаягдлын тухай хуулийн шаардлагад нийцүүлэн аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад дахин ашиглалтад хүлээлгэн өгөв.



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хаягдал тосны хэмжээ 5.0тн бөгөөд тээвэрлэлтийг “Зэс эрдэнийн хувь” ХХК-иас хийж “Аюултай хог хаягдлын дагалдах бичиг”-ээр баталгаажуулан “Монпити ойл” ХХК-ийн Орхон аймаг, Баян-Өндөр сум, Малчин баг, Нарийн хөндий 3 замын уулзвар дахь үйлдвэрийн байранд хүлээлгэн өгөв.

Зураг-71. Хаягдал тос хүлээлгэн өгч буй байдал



11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйл “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”, 9.7 дахь заалт “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана”, “Байгаль орчны менежментийн



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2.7-д “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсэж болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тодорхой тусгана” хэмээн заасан байна. Үүний дагуу бид байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллав.

11.1. Агаарын чанарын хяналт шинжилгээ

Төслийн талбай орчмын агаарын чанарын хяналт шинжилгээг Монгол улсын Итгэмжлэгдсэн лаборатори болох Орхон аймгийн УЦУОШТөвийн БОШЛ, Улаанбаатар хот БОХЗТЛ-д 6 цэгт хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/ Нийт тоос, дуу шуугиан, 3 цэгт нарийн ширхэглэгт тоос/PM_{2.5}/, том ширхэглэгт тоос /PM-10/ шинжилгээг хийлгэв. MNS 17-2-5-12:2021 Байгаль орчин. Агаар дахь хүхэрлэг хийн агууламжийг тодорхойлох Тетрахлормеркурат натрийн арга, MNS 17-2-5-11:2021 Байгаль орчин. Агаар дахь азотын давхар ислийн агууламжийг тодорхойлох Гриссийн арга стандартуудын дагуу гүйцэтгүүлж байна. Шинжилгээний үр дүнг Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартад харьцуулан үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулан ажиллаж байна.

Хүснэгт-27. Агаарын чанарын хяналт шинжилгээний цэгүүд

№	Цэгийн байршил	Солбицол		Шинжилгээний үзүүлэлтүүд	код
1	Катодын зэс боловсруулах үйлдвэрийн технологийн зам	х-0435572	у-5426885	SO ₂ , NO ₂ , Нийт тоос мг/м ³ , дуу чимээ дБ(А)	АЧ-1
2	Үйлдвэрийн орчим SX, EW	х-0436117	у-5426576	SO ₂ , NO ₂ , Нийт тоос мг/м ³ , дуу чимээ дБ(А), PM _{2.5} , PM-10 мг/м ³	АЧ-2
3	Бутлуур орчимд	х-0436269	у-5427040	SO ₂ , NO ₂ , Нийт тоос мг/м ³ , дуу чимээ дБ(А), PM _{2.5} , PM-10 мг/м ³	АЧ-3
4	Нуруулдан уусгах байгууламж орчимд	х-0436269	у-5427040	SO ₂ , NO ₂ , Нийт тоос мг/м ³ , дуу чимээ дБ(А)	АЧ-4
5	Уурын зуухны яндангийн дэргэд	х-0436068	у-5426336	SO ₂ , NO ₂ , Нийт тоос мг/м ³ , дуу чимээ дБ(А), PM _{2.5} , PM-10 мг/м ³	АЧ-5
6	Түлшний нөөцийн сав орчимд	х-0436119	у-5426570	SO ₂ , NO ₂ , Нийт тоос мг/м ³ , дуу чимээ дБ(А)	АЧ-6

Зураг-72. Агаарын чанарын хяналт шинжилгээний цэгүүдийн байршил



Зураг-73. Агаарын чанарын хяналт шинжилгээний сорьц авч буй байдал





11.2. Хөрсний чанарын хяналт шинжилгээ

Төслийн талбай орчмын хөрсний чанарын хяналт шинжилгээг “Ханлаб” ХХК-ийн Эрдэс судлалын лабораторид хими, хүнд металл, нян, ШУА-ын Газарзүй Геоэкологийн хүрээлэнгийн хөрс судлалын лабораторид хөрсний химийн үндсэн хэв шинж, механик бүрэлдэхүүн, Орхон аймгийн УЦУОШТ-ийн БОШЛ-д хөрсний агрохими, нефтийн бүтээгдэхүүний шинжилгээг хийлгэж ажиллав. “Хан лаб” ХХК-д хүргүүлсэн хөрсний сорьцуудад төмөр-Al(мг/кг), мишъяак-As(мг/кг), бари-Ва(мг/кг), Берин-Ве(мг/кг), Билли-/Bi(мг/кг), Калци-Са(мг/кг), Кадми-Cd(мг/кг), Кобальт-Со(мг/кг), Хром-Cr(мг/кг), Зэс-Cu(мг/кг), Төмөр-Fe(мг/кг), Кали-К(мг/кг), лантан-La(мг/кг) лити-Li(мг/кг), магни-Mg(мг/кг), манган-Mn(мг/кг), молибден-Mo(мг/кг), никель-Ni(мг/кг), фосфор-P(мг/кг), хар тугалга-Pb(мг/кг), сурьма-Sb(мг/кг) силен-Se(мг/кг), стронци-Sr(мг/кг), титан-Ti(мг/кг), ванад-V(мг/кг), иттри-Y*(мг/кг), цайр-Zn(мг/кг), циркон-Zr(мг/кг) гэсэн 28 үзүүлэлтээр шинжилгээ хийлгэв. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын дээд хамжээ MNS5850:2019 стандартад харьцуулан үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулан ажиллаж байна.

Хүснэгт-28. Хөрсний хяналт шинжилгээний цэгүүд

№	Хөрсний мониторингийн цэг	Солбицол		Шинжилгээний төрөл	Код
		уртраг	өргөрөг		
1	Өдрийн хэрэглээ (Хүхрийн хүчлийн агуулах)	104° 07' 34.3"	48° 59' 19.9"	агрохими, хүнд металл, механик бүрэлдэхүүн	ХЧ-1
2	Үйлдвэрийн бүс (SX, EW үйлдвэрийн дунд)	104° 07' 35.0"	48° 59' 18.0"	агрохими, хүнд металл, механик бүрэлдэхүүн	ХЧ-2
3	Төмрийн хаягдал	104° 07' 49.4"	48° 59' 12.6"	агрохими, хүнд металл, механик бүрэлдэхүүн	ХЧ-3
4	Бутлуур (“Хас санч” ХХК)	104° 07' 44.5"	48° 59' 33.2"	агрохими, хүнд металл, механик бүрэлдэхүүн	ХЧ-4
5	Нуруулдан уусгалтын талбай-1, CELL2 урд хэсэг	104° 07' 26.2"	48° 59' 23.9"	агрохими, хүнд металл, механик бүрэлдэхүүн	ХЧ-5
6	Хяналт (үйлдвэрийн бүсийн гадна)	104° 07' 14.2"	48° 59' 09.5"	агрохими, хүнд металл, механик бүрэлдэхүүн	ХЧ-6



Зураг-75. Хөрсний чанарын шинжилгээний сорьц





“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

11.3. Усны чанарын хяналт шинжилгээ

Усны чанарын хяналт шинжилгээ: Ханлаб” ХХК-ийн Эрдэс судлалын лабораторид хими, хүнд металл рН, Кали(K^+) мг/л, Натри(Na^+) мг/л, Кальци (Ca^{2+}) мг/л, Магни (Mg^{2+})мг/л, Аммони(NH^{4+}) мз/л, Хлорид(Cl)мг/л, Сульфат(SO_4^{2-})мг/л, Нитрит(NO_2^-)мг/л, Нитрат(NO_3^-)мг/л, Карбонат(CO_3^{2-})мг/л, Гидрокарбонат (HCO_3^{2-})мг/л, Нийт хатуулаг мг-экв/л, Хуурай үлдэгдэл, TDS мг/л, Цахиурын хүчил H_2SiO мг/л, Исэлдэх чадвар $KMnO_4$ мгO₂/л, Фосфат (PO_4^{3-})мг/л, Фтор (F)мг/л, Хүхэрт ус төрөгч (H_2S)мг/л, Чөлөөт хлорид (Cl)мг/л, Булингар NTU, Мөнгө (Ag) мг/л, Хөнгөн цагаан (Al) мг/л, Мышьяк (As)мг/л, Бор (B) мг/л, Бари (Ba) мг/л, Берелли (Be) мг/л, Кадми (Cd) мг/л, Кобальт (Co) мг/л, Хром (Cr) мг/л, Зэс (Cu) мг/л, Төмөр (Fe) мг/л, Марганец (Mn) мг/л, Молибден (Mo)мг/л, Никель (Ni) мг/л, Хар тугалга (Pb) мг/л, Сурьма (Sb)мг/л, Селен (Se)мг/л, Стронци (Sr) мг/л, Уран (U) мг/л, Цайр (Zn)мг/л гэсэн нийт 43 үзүүлэлтээр тус тус шинжилгээг гүйцэтгүүлэв.


Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018, Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ахуйн хаягдал бохир усны шинжилгээг Орхон аймгийн БОШЛ-д рН, БХХ5 мгO/л, Фосфат (PO_4^{3-})мг/л, Ж.б мг/л, Нитрит(NO_2^-)мг/л, Нитрат(NO_3^-)мг/л, Аммони (NH^{4+}) мз/л гэсэн үзүүлэлтээр Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS4943:2015 стандартад харьцуулан үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулан ажиллав.

Хүснэгт-29. Усны хяналт шинжилгээний цэгүүд


№	Шинжилгээний үзүүлэлтүүд	Солбицол		Шинжилгээний цэгүүд
		Уртраг	өргөрөг	
1	MNS 0900:2018 Ерөнхий үзүүлэлт, химийн үзүүлэлт, хүнд металл	104 ⁰ 07'40,81''	48 ⁰ 59'13,25''	Худаг-02 (мг/л)
2		104 ⁰ 07'45,6''	48 ⁰ 59'13,9''	Худаг-03 (мг/л)
3		104 ⁰ 07'49,43''	48 ⁰ 58'56,23''	Худаг-04 (мг/л)
4	Сульфат (SO ₄), рН, Зэс(Cu) MNS6148:2010	104 ⁰ 07'29,6''	48 ⁰ 59'24,2''	Гүний усны хяналтын цооног-1
5		104 ⁰ 07'40,5''	48 ⁰ 59'21,0''	Гүний усны хяналтын цооног-2
6		104 ⁰ 07'40,3''	48 ⁰ 59'26,1''	Гүний усны хяналтын цооног-3
7		104 ⁰ 07'43,2''	48 ⁰ 59'13,9''	Гүний усны хяналтын цооног-4
8	MNS4943:2015 рН, Ж.б, ХХХ, БХХ5, HN ₄ , NO ₂ , NO ₃ , N нийт, P эрд	104 ⁰ 07'37,42''	48 ⁰ 59'12,29''	Хаягдал бохир ус-ахуйн (мг/л)



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан
Зураг-76. Усны хяналт шинжилгээний цэгүүдийн байршил



Зураг-77. Усны чанарын сорьц





11.4. Бактерлогийн хяналт шинжилгээ

Бактерлогийн хяналт шинжилгээ: 9042776 регистрийн дугаартай, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Уурхайчин баг ДГТ-III хаягт байрлах Стандарт хэмжилзүйн хэлтэс Нян судлалын лаборатори/МУ-н итгэмжлэгдсэн/-д MNS3297:1991 стандартын дагуу ундны усны сорьцод нянгийн ерөнхий тоо, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч бактери - ГБЭТБ Салмонелла, Хөрсний сорьцод гэдэсний бүлгийн савханцрын таныц, Клостридиум перпрингенс, MNS4943:2015 стандартуудын дагуу ахуйн хаягдал бохир усанд Тунгалаг(см), рН, Аммонийн ион, (мг/л), Жинлэгдэх бодис, (мг/л), Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, (мгО/л), Химийн хэрэгцээт хүчил төрөгч, Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч зэрэг шинжилгээнүүдийг гүйцэтгүүлж байна.

Хүснэгт-30. Бактерлогийн хяналт шинжилгээний цэгүүд

Сорьцын дугаар	Сорьц авсан цэгийн нэр	Сорьц авсан цэгийн координат	Шинжлэх үзүүлэлтүүд мг/м ³
Усны бактерлогийн шинжилгээ			
№01	Гүний худгийн ус (ЗЭХ-02)	х-0436203.49 у-5426380.11	ББЕТ, Salmonella spp, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян
№02	Гүний худгийн ус (ЗЭХ-03)	х-0436288 у-5426403	ББЕТ, Salmonella spp, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян
№03	Нийтийн хоол үйлдвэрлэлийн усны сав	х-0435904 у-5426418	ББЕТ, Salmonella spp, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян
№04	Нийтийн хоол үйлдвэрлэлийн крантны ус	х-0435904 у-5426418	ББЕТ, Salmonella spp, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян
Хөрсний бактерлогийн шинжилгээ			
№05	Гүний худаг	х-0436288 у-5426403	ББЕТ, Salmonella spp, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян
№06	Нүхэн жорлон (үйлдвэр, кэмп)	х-0436009 у-5426343	ББЕТ, Salmonella spp, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№07	Түр хогийн цэг	х-0436209 у-54264349	ББЕТ, Salmonella spp, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян
№08	Цэвэрлэх байгууламж	х-0436165 у-5426358	ББЕТ, Salmonella spp, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян
№09	Нүхэн жорлон (“Персиммон” ХХК)	х-0437051.14 у-5427005.46	ББЕТ, Salmonella spp, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян
Бохир усны хими, бактерлогийн шинжилгээ			
№10	Цэвэрлэх байгууламж оролт	Х-436133.32 У-5426381.88	Тунгалаг(см), рН, Аммонийн ион, (мг/л), Жинлэгдэх бодис, (мг/л), Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, (мгО/л), Химийн хэрэгцээт хүчил төрөгч, Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч
№11	Цэвэрлэх байгууламж гаралт	Х-0436135.49 У-5426349.08	

Зураг-78. Бактерлогийн шинжилгээний сорьц



12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

12.1. Мэргэжлийн байгууллагаар Байгаль орчны аудит хийлгэх


Байгаль хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйл. Байгаль орчны аудит, 10.1 дэх заалт “Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ” гэж заасан байдаг.

2023 онд “Ногоон гэрэлт ирээдүй” ХХК-иар Байгаль орчны төлөвлөгөөт аудит гүйцэтгүүлж байна. Ажил гүйцэтгэх гэрээний дагуу “Ногоон гэрэлт ирээдүй” ХХК-иас мэргэжлийн аудиторуд 2023 оны 7 сарын 21-нд “Катодын зэс боловсруулах үйлдвэр”-ийн бүсэд ажиллан холбогдох хууль журмын дагуу “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн “Катодын зэс боловсруулах үйлдвэр”-ийн байгаль орчны төлөвлөгөөт аудитыг гүйцэтгэв.

Зураг-79. Байгаль орчны төлөвлөгөөт аудитын тайлан




“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



12.2. Байгаль орчны мониторинг үнэлгээ хийлгэж

“Экологийн бүтээмж групп” ХХК-тай байгуулсан 2023 оны 01 сарын 31-ний өдрийн №09/23.01 тоот “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн “Катодын зэс боловсруулах үйлдвэр”-ийн талбайн Байгаль орчны хяналт шинжилгээ, үнэлгээ зөвлөх үйлчилгээний ажлыг холбогдох норм, стандарт, журмын дагуу хийж гүйцэтгэх, үйлдвэрлэлийн нөлөөллөөс үзүүлж болзошгүй байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэсэн санал зөвлөмж боловсруулах, тайлангийн үр дүнг холбогдох тайлан, зөвлөмжийн хамт хүлээн авахаар гэрээг байгуулсан.

Зураг-80. Байгаль орчны мониторинг үнэлгээний тайлан





“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Орхон аймгийн Баян-Өндөр суманд байрлах “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн “Катодын зэс боловсруулах үйлдвэр”-ын төслийн хээрийн болон суурин судалгааны ажлын үр дүнд бид дараах дүгнэлт, зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- Төслийн байгаль орчны төлөв байдлыг тодорхойлохдоо БОНХЯ-ны 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан аргачлалд тусгагдсан байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх аргачлалыг ашиглав;
- Төслийн талбай байрлах бүс нутаг нь Монгол орны гадаргын усны ангиллаар Хойд мөсөн далбайн ай савд, Орхон голын сав газарт багтана;
- Бид хээрийн судалгааг 2023 оны 10-р сарын 03-ны өдөр хийж гүйцэтгэн холбогдох аргачлалын дагуу хөрсний дээж авч, унд, ахуйн уснаас MNS 5667-11:2000 (Гүний уснаас дээж авах зөвлөмж) стандартыг баримтлан усны 1 сорьц авч тус бүрийг “Нарт шүүн” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн;
- Унд, ахуйн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, бага хатуулагтай ус байна. Шинжлүүлсэн бүх үзүүлэлтүүд нь MNS 0900:2018 (Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын) стандартын шаардлагыг хангаж байна;
- Төслийн талбайд бүхэлдээ сайр чулуурхаг хар шороон хөрс тархжээ;
- Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж бага, өнгөн хэсэгт карбонат илрээгүй, шингээгдэх сууриудын нийлбэр хэмжээ дунд зэрэг, цахилгаан дамжуулах чанар болон давсны агууламж маш бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор дунд-их, калийн хангамж бага- их байна;
- Хөрсний дээжид хүнд металлын шинжилгээг атомын шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлсон бөгөөд гарсан үр дүнг (MNS 5850:2019) Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна;
- Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж бага, өнгөн хэсэгт карбонат илрээгүй, шингээгдэх сууриудын нийлбэр хэмжээ бага, цахилгаан дамжуулах чанар болон давсны агууламж маш бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор агууламж болон калийн хангамж бага байна;



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

- Хөрсний дээжид хүнд металлын шинжилгээг атомын шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлсон бөгөөд гарсан үр дүнг (MNS 5850:2019) Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад Хром (Cr), Кадмий (Cd), Никель (Ni), Цайр (Zn), Зэс (Cu) зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна;
- Харин Хар тугалга (Pb)-ын хэмжээ нь элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй ижил түвшинд гарсан байна. Цаашид саармагжуулах арга хэмжээ авах, хөрсний лабораторид тогтмол шинжлүүлэх шаардлагатай;
- Орхон аймагт Улсын тусгай хамгаалалттай газар нутгууд байхгүй байна;
- Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт байрлах төслийн талбай нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна;
- Төслийн талбай орчмын агаарын чанарыг тодорхойлох зорилгоор том ширхэгт тоосонцор (PM10) болон нарийн ширхэгт тоосонцор (PM2.5)-ыг DustTrak TSI 8520 маркийн зөөврийн багаж ашиглан хэмжилт хийсэн. Мөн дуу шуугиан буюу физик бохирдлыг тодорхойлох зорилгоор Digital Sound Level Meter зөөврийн багажаар хэмжилтийг тус тус хийсэн. Судалгааны үр дүн тус бүрийг “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016” стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байсан;
- Төслийн болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэрийг тодорхойлоход төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр хөрс, ургамлын бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдож, шууд, урт хугацаанд сөрөг нөлөөлнө. Харин дэд бүтцийн хөгжил болон орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэргээр эергээр урт хугацаанд шууд нөлөөлнө;

ЗӨВЛӨМЖ

- Төсөл хэрэгжүүлэгч байгууллага дотооддоо хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулан бүх ажилчдыг үйлдвэрийн хүрээнд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон ХАБЭА-ын чиглэлээр гарсан олон улсын хөдөлмөрийн байгууллагын дүрэм журмууд, бусад хууль эрхийн актууд, болон байгууллагын дотоод хөдөлмөр аюулгүйн журмыг дагаж мөрдүүлэх, аюулгүй хувцас хэрэглэлээр тогтмол хангах, сургалт зөвлөгөөг тогтмол явуулах, хяналт тавьж ажиллах;
- Төслийн үйл ажиллагааны талаар мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар зөвлөмжийг бүрэн дагаж мөрдөх, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй”. Шуугианы норм, аюулгүй



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000, Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах шаардлага MNS 4996: 2008, Ажлын байрны орчны эрүүл ахуйн шаардлага” MNS 4990:2015 стандартуудыг чанд баримтлан ажиллах;

- Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс орон нутгийн төр захиргааны, болон байгаль хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, мэргэжлийн туслалцаа авч үйл ажиллагаагаа явуулж буй газар нутгийнхаа байгаль орчныг хамгаалах ажлыг гүйцэтгэх нь байгаль орчны үзэсгэлэнт төрхийг хадгалахад илүү дөхөмтэй болохыг анхаарч ажиллах нь чухал юм;
- Байгалийн гэнэтийн гамшигт үзэгдэл, цахилгаан эрчим хүчний нөхцөлөөс хамаарах аюул осол тохиолдож болзошгүй болохыг төсөл хэрэгжүүлэх шатанд онцгой анхаарч, зохих ёсны урьдчилан сэргийлэх байгууламж, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай;
- Хог хаягдлын ангилан ялгах, тогтмол хугацаанд графикийн дагуу хог хаягдлыг гэрээний дагуу зөөж тээвэрлүүлж байх хэрэгтэй;

12.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний барьцаа хөрөнгө байршуулах

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10. Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ.

Зураг-81. БОМТ-ний барьцаа хөрөнгө-2023он

Худалдаа Хөгжлийн Банк

Системийн огноо: **2023.03.09**

Нэр: **ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ ХХК**

Огноо: **2023.03.09 13:23:20**

Шилжүүлгийн мэдээлэл

Журналын №: **93670658**

Илгээгч	Дансны дугаар: 432020941	Нэр ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ ХХК	Дүн 42,192,062.50 MNT	Ханш 1.00
/ дөчин хоёр сая нэг зуун ерэн хоёр мянга жаран хоёр төгрөг тавин мөнгө /				
Хүлээн авагч	Банкны дугаар: 90 Дансны дугаар 100900013406	Банкны нэр Төрийн сан Нэр БО нөхөн сэргээх баталгаа	42,192,062.50 MNT	1.00

Гүйлгээний утга:
EB -5388082 Зэс эрдэнийн хувь

Танд баярлалаа

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан

Салбар, тооцооны төв:
Гарын үсэг: Б Энхтайван салбар Теллер №02

Тамга:

Огноо: _____ Он _____ Сар _____ Өдөр

2023 -03- 0 9



13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5. “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн оршин суугчдад танилцуулах ажлыг зохион байгуулна” хэмээн заасан байдаг. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 1 сарын 6-ны өдрийн А-03 тоот “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-ын дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллав.

13.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг орон нутгийн ард иргэдэд тайлагнах

“ТАНЫ ОРОЛЦОО-БИДНИЙ ИРЭЭДҮЙД” урианы дор зохион байгуулах нээлттэй хаалганы өдөрлөг: Орхон аймгийн “Байгаль орчин, аялал жуулчлалын газар”-ын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр №144 тоот байгаль хамгаалах хаврын сарын ажлын хүрээнд “ТАНЫ ОРОЛЦОО-БИДНИЙ ИРЭЭДҮЙД” урианы дор зохион байгуулах нээлттэй хаалганы өдөрлөгт “Зэс эрдэнийн хувь” ХХК-иас Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй байгаль орчны хэлтэс, Хувьцаа эзэмшигчидтэй харилцах менежерүүд оролцов.



Тус өдөрлөг 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр А.Амарын талбайд зохион байгуулагдсан бөгөөд манай компани нь байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Ногоон-Эрдэнэт хөтөлбөрийг дэмжих хүрээнд 2022 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, судалгааны ажлуудыг танилцуулж цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөний талаар иргэдэд мэдээлэл өгч гарын авлага тараан өдөрлөгт идэвхтэй оролцлоо.

Тус нээлттэй хаалганы өдөрлөгөөр манай компани нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээлэл, тайланг нийт 58 иргэд өгч ажилласан бол ажилчид иргэдэд мэдээлэл өгөх гарын авлага 200 ширхэг тарааж ажиллав. Мөн манай компани нь Монголд анх удаа 24500 гаруй хувьцаа эзэмшигчид, иргэдийн хувь хөрөнгийг нийлүүлэн босгож, уул уурхайн төслийн үр шимийг олон мянган иргэд хүртэж болохуйц жишиг загварыг гаргахаар зорин ажиллаж буй “Катодын зэс боловсруулах үйлдвэр”-ийн төсөл хэрэгжүүлэгч тул ард иргэд, хувьцаа эзэмшигчдэдээ хувьцааны талаарх мэдээллийг нээлттэй олгож ажиллав.

Зураг-82. Нээлттэй хаалганы өдөрлөг



“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан





“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

13.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хувьцаа эзэмшигчдэд тайлагнах

“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн дунд “Үйлдвэрийн бүтээн байгуулалт”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ”, “Байгаль орчны бодлого” гэсэн чиглэлээр нээлттэй хурлыг зохион байгуулав. Хуралд нийт 400 орчим иргэд оролцсон юм.

Зураг-83. Хувьцаа эзэмшигчдийн хурал

